MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,117.429... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.11.24. Пүрэв. №211, 212 (4581, 4582) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




ОНЦЛОХ ХУУДАС

МЭРГЭЖЛИЙН САЙД

V нүүрт

ДЭЛХИЙ

Р.ЭРДОГАНЫ ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ ҮРГЭЛЖИЛСЭЭР...

VIII нүүрт

Дугаарын 60 мөр

## Бага ангийн сурагчдыг амраая

Н.БАТЗАЯА

Улаанбаатар хот олон янзын л нэртэй болж байх шиг байна. Нэг хэсэг Утаанбаатар гэх нэр зүүж байсан бол одоо Улаанбаатар мөсөн гулгуурын талбай боллоо гээд хэлчихэд хилсдэхгүй биз. Хаа, сайгүй л хальтирч унасан хүн, гулгаанаас болж хоорондоо шүргэлдсэн машин тэрэг үзэгдэх болсон нь ийнхүү нэрлэхэд хүргэсэн. Машин тэрэг шүргэлцэх ч яах вэ замын цагдаа, даатгалын газраа дуудаад хоорондоо учраа олох биз. Харин энэ хальтиргаа, гулгаатай холбоотой хэлэх нэг зүйл байна. Хотын гудамж талбайд үүссэн мөс, хүн явахын аргагүй болтол гөлийсөн замын хохирогч нь хэн болж байна вэ гэвэл яалт ч үгүй иргэд.

**Үргэлжлэл нь III нүүрт**



ҮЗЭЛ БОДОЛ

# ЕРӨНХИЙ САЙДЫН ОРОН НУТАГ ДАХЬ ТОМИЛГООНД АҮНЭЛГЭЭ ӨГЬЕ

Ч.ЧУЛУУН

Мэргэжлийн гэх тодотголтой Засгийн газарт мэргэжлийн бус хэд хэдэн хүнийг сайдаар томилсныхоо шанг Ерөнхий сайд намрын гурван сард ханатлаа хүртсэн. Түүний байгуулсан Засгийн газар ямар төвшинд ажиллаж буйг та бид мэдэх юм хойно энэ тухай нурших нь илүүц биз. Харин Засгийн газрын анхан шатны нэгж болох хөдөө, орон нутгийн Засаг дарга нарын тухайд хэл ам, хэрүүл шуугиан болоогүй нь нутгийн иргэдийн сэтгэлд нийцсэн томилгоо болсон гэлтэй. Ямартай ч, төсвийн шинэ захирагч нар орон нутгийн сонгуулийн ард гарцгааж, хаалга тогшин аюулын харанга дэлдээд байгаа бичин жилийн өвлийг гарз хохирол багатайгаар давж гарахыг юуны түрүүнд эрэлхийлж байгаа нь "Монголын мэдээ" сонины сэтгүүлчдийн багийн ажилласан зургаан аймагт мэдрэгдэж байлаа.

### ДЦС–ыг чухалчилсан Ш.Оргил

Монгол Улсын хойд хил болох Сэлэнгэ аймагт өвлийн эхний цастай уралдан хөл тавьсан. Хөгжил дэвшлээрээ тааруу хэмээн яригддаг ч Монгол Улс зуурах гурил, идэх талхтай байхыг шийддэг хэмээн хэлж болох эл аймгийг Ш.Оргил хэмээх дулааны инженер залуу удирдахаар болжээ. Сэлэнгэ аймгийн Дулааны цахилгаан станцын дарга, аймгийн Засаг даргын орлогчоор тус тус ажиллаж байсан тэрбээр "Сэлэнгэчүүд өвлийг өнөтэй давна гэдэгт эргэлзэх зүйл алга. Өвөлжилтийн бэлтгэл хангагдсан. Ургацаа хураагаад дууссан. Га тутмаас хураасан ургацын амжилтаа бид энэ жил бататгаж чадлаа. Энэ бол сэлэнгэчүүдийн хувьд том амжилт.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ЗАСГИЙН ГАЗАР

# БААСАН ГАРАГТ БҮХ НИЙТЭЭРЭЭ АМРАХААР БОЛЛОО

Э.ТУУЛ

*Монгол Улсын Засгийн газрын ээлжит хуралдаан өчигдөр болж, нэлээд олон асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Хамгийн түрүүнд Улс тунхагласны баярын өдрийн амралтыг арваннэгдүгээр сарын 25 буюу энэ баасан гарагт шилжүүлж, бүх нийтээр амрах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. УИХ-аас жил бүрийн арваннэгдүгээр сарын 26-ны өдрийг Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр хэмээн нийтээр тэмдэглэх баярын өдөр болгон хуульд өөрчлөлт оруулсан юм. Гэтэл энэ жил арваннэгдүгээр сарын 26 нь бямба гарагт таарч байгаа тул баярын амралтыг ийнхүү шилжүүлэхээр болсон бөгөөд Засгийн газрын хуралдаанаар дээрх асуудлыг дэмжиж, энэ баасан гарагт бүх нийтээрээ амрахаар боллоо.*

### Сумдын эмнэлэгт яаралтай машин олгохоор болов

Өвөлжилт хүндэрч, зуд болж болзошгүй талаар сүүлийн хэдэн өдрийн турш ярьж байгаа билээ. Тэгвэл байгаль, цаг уурын энэхүү хүнд үед орон нутгийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх ёстой сумын эмнэлгүүдийн яаралтай тусламжийн машины ашиглалт болон гүйлт, нормын хугацаа дуусч, эвдэрсэн байгаа аж.

**Үргэлжлэл нь II нүүрт**

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА




*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

# Д.ЭРДЭНЭБАТ: АН-ын лидерүүдийг нэг нэгээр нь баривчилж буй асуудлаар үндэслэлтэй мэдээлэл цацна

Ж.ОТГОН

*УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат Ардчилсан намын Их хурлыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагчаар томилогдон ажиллаж байгаа билээ. Тиймээс Их хурлын бэлтгэл ажил болоод бусад асуудлын талаар ярилцлаа.*

**-АН-ын VI их хуралд хэчнээн төлөөлөгч оролцох тооцоо гараад байна вэ?**

-ҮЗХ-оос АН-ын VI их хурлыг хуралдуулах ажлын хэсгийг байгуулсан. 2016 оны арванхоёрдугаар сарын 06-нд Улаанбаатар хотноо АН-ын VI их хурал 1210 төлөөлөгчтэй хуралдах болно. Тиймээс одооноос төлөөлөгчдийг сонгох, журмыг батлаад байна. Энэ удаагийн хуралдааны үндсэн гол зорилго бол АН-ын үзэл баримтлал, үндсэн дүрмийн шинэчилсэн дүрмийг батлах хуралдаан болно.

**Үргэлжлэл нь IV нүүрт**




| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах | Худалдаа хөгжлийн банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2442.00 | 2458.00 | ФУНТ | 2983.00 | 3088.00 | 2440.00 | 2458.00 | ФУНТ | 3000.00 | 3111.00 |
| ЕВРО | 2568.00 | 2640.00 | РУБЛЬ | 36.80 | 40.00 | 2566.00 | 2664.00 | РУБЛЬ | 37.20 | 40.86 |
| ИЕН | 21.83 | 22.37 | ЮАНЬ | 353.00 | 359.40 | 21.73 | 22.58 | ЮАНЬ | 353.00 | 359.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ЗАСГИЙН ГАЗАР

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тиймээс энэхүү асуудлыг шийдэх хүрээнд сумдын эмнэлэгт туулах чадвар сайтай, УАЗ маркийн 22 автомашиныг яаралтай олгож, хөрөнгийг 2017 оны төсвийн багц, Засгийн газрын нөөц сангаас гаргахаар боллоо.


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# БААСАН ГАРАГТ БҮХ НИЙТЭЭРЭЭ АМРАХААР БОЛЛОО

## Монгол, Оросын Засгийн газар хоорондын комисс хуралдана

Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдааныг ирэх сарын 11-13-ны хооронд Улаанбаатар хотод хийхээр хоёр тал тохирчээ. Хоёр улсын Засгийн газар хоорондын Комиссын хуралдаанаар худалдаа, эдийн засаг, дэд бүтэц, тээвэр, уул уурхай, эрчим хүч, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагаа зэрэг олон чухал асуудлыг хэлэлцэх юм байна. Уг хуралдаанд оролцох Монголын талын төлөөлөгчдийн баримтлах удирдамжийг өчигдрийн Засгийн газрын хуралдаанаар зөвшөөрлөө. Монгол талын төлөөлөгчдийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд тус комиссын Монголын хэсгийн дарга У.Хүрэлсүх ахлахаар болжээ.

## Гемодиализын эмчилгээний зардлыг төр хариуцна

Бөөрний хурц болон архаг дутагдалтай иргэдийн бөөр орлуулах-гемодиализ эмчилгээний тасралтгүй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор энэ чиглэлийн эмнэлгийн тус-ламж, үйлчилгээ эрхлэх тус-гай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гемодиа-лизийн эмчилгээг гүйцэтгүүлэх Засгийн газрын тогтоол батал-лаа. Уг эмчилгээний төлбөрийг төрөөс хариуцах бөгөөд зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж байхыг холбогдох сайд нарт даалгалаа. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд төр, хувийн хэвшлийн 27 байгууллагад бөөр орлуулах 169 ширхэг гемодиализын аппарат ажиллаж байгаа юм. Улсын хэмжээнд 564 хүн энэ төрлийн эмчилгээнд орох шаардлагатай бөгөөд өдөрт 2-3 хүн шинээр оношлогдож байгааг мэргэжлийн байгууллага тооцож гаргажээ. Эмчилгээний заалтаар бол нэг хүн долоо хоногт гурван удаа, насан туршдаа гемодиализын эмчилгээ хийлгэх бүртээ хувийн эмнэлэгт 100-120 мянган төгрөгийн төлбөр төлөх шаардлагатай болдог аж. Мөн жилд дунджаар 20 орчим сая төгрөг зарцуулдаг байна. Энэ зардлыг төрөөс хариуцахаар боллоо.

## 300 ортой төрөх эмнэлгийг концессоор барьж дуусгана

"Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ортой төрөх эмнэлгийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц барих төсөл"-ийн концесс олгох уралдаант шалгаруулалтын явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат Засгийн газрын хуралдаанд танилцууллаа. Төслийг "Зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх" төрлөөр уралдаант шалгаруулалтын аргаар хэрэгжүүлэхээр Засгийн газар 2013 онд шийдвэрлэсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 68 хувьтай байсан ч төсвөөс санхүүжүүлэх боломжгүй болсноос ажил нь зогсоод байгаа юм. Төслийн уралдаант шалгаруулалтыг энэ оны тавдугаар сард зарласан бөгөөд нэг компани саналаа ирүүлээд байна. Иймээс цаашид уралдаант шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг Үндэсний хөгжлийн газарт даалгалаа. Энэхүү төсөл хэрэгжвэл ЭМД-ын сангаар эх, хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, олон улсын стандартын шаардлага хангасан, 140 ортой амаржих газар, хүүхдийн 160 ортой төрөлжсөн нарийн мэргэжлийн төв бүхий эх, хүүхдийн цогц эмнэлэгтэй болох юм.

## 2017 онд тусгай зориулалтаар 68 угалз агнана

2017 онд тусгай зориулалтаар 68 угалз, 75 тэх, 32 халиу буга болон бор гөрөөс 10, зэрлэг гахай 10, цагаан зээр 100, агнуурын шувуу 400 толгойг хүртэл агнуулахаар, тул загас 500 толгойг барьж буцаан тавиулахаар Засгийн газраас тогтоолоо. Мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтээс үзвэл дээрх тооны ан амьтан агнуулахад тоо толгойн өсөлтөд сөргөөр нөлөөлөхгүй юм. Мөн хуралдаанаар агнуурын амьтны нэг тоо толгойд ногдуулах жишиг үнэ, төлбөр, хураамжийг 2001, 2005 оны инфляцийн төвшин, мэргэжлийн байгууллага, Шинжлэх ухааны академи, Сорилын биологийн хүрээлэнгийн санал зэргийг харгалзан 30 хүртэл хувиар нэмлээ. Ингэснээр ирэх онд улсын төсөвт гурван тэрбум гаруй төгрөгийн орлого орно гэж тооцоолж байна. 2016 онд 60 угалз, 70 тэх, 30 халиу буга, 20 саарал чоно, тус бүр 10 зэрлэг гахай, бор гөрөөс, 150 цагаан зээр, 400 хүртэл агнуурын шувууг агнуулах, 400 тул загас барьж буцаан тавиулахаар 2015 онд шийдвэрлэж байжээ. Амьтны нөөц ашигласны төлбөрт 13 аймгийн 37 сумын төсөвт 940 гаруй сая төгрөг ороод байгаа аж.

## БХИС–ийг Үндэсний батлан хамгаалахын их сургууль болголоо

Аюулгүй байдал, цэрэг, батлан хамгаалах чиглэлээр сургалт, судалгаа эрхлэх чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Батлан хамгаалахын их сургуулийг Үндэсний батлан хамгаалахын их сургууль болголоо. Ингэснээр батлан хамгаалахын бодлого, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн "Сургууль төвт" тогтолцоо бий болох үндэс бүрдэж, дэлхийн олон орны ижил төрлийн сургалтын байгууллагатай адил төвшинд очих, ижил стандартаар сургалт явуулах бололцоотой болох юм. Мөн багшлах боловсон хүч чадваржиж мэргэшин, зохион байгуулалт, нөөцийн бодит дэмжлэг бий болно. Манай улсын батлан хамгаалах салбартай хамтын ажиллагаатай АНУ, БНХАУ, Турк, БНСУ зэрэг олон орны Үндэсний батлан хамгаалахын сургууль, бүс нутгийн болон олон улсын байгууллага, холбоотой харилцахад "Үндэсний" гэх тодотгол нь статусыг нь өргөж, илүү өргөн хүрээнд, харилцан итгэлцэлд тулгуурлан адил төвшинд хамтран ажиллах нөхцөл, боломж бүрдэнэ гэж Батлан хамгаалах яам үзжээ.

## Засгийн газрын тогтоол баталлаа

Засгийн газрын ээлжит хуралдаанаар хөрс, бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой асуудлаар "Засгийн газарт чиглэл өгөх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн төслийг хэлэлцэн зарчмын хувьд дэмжиж хэд хэдэн саналыг уламжлахаар болсон. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, Хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг тус тус баталлаа. Түүнчлэн Монголын оюутны спортын IV их наадмыг 2017 онд орон даяар зохион байгуулах Засгийн газрын тогтоол баталлаа. Үүнээс гадна өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар мэдээллээ. Үүнд энэ оны гуравдугаар улиралд Засгийн газрын гишүүд, яам, агентлагийн удирдлагад хандан иргэдээс 40 орчим мянган өргөдөл, гомдол, санал хүсэлт ирсний 37 мянга гаруйг нь хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Энэ нь 95 орчим хувьтай гэсэн үг юм. Засгийн газарт хандсан иргэдийн дийлэнх нь нийгмийн халамжид хамрагдах, мөнгөн тусламж, тэтгэвэр, тэтгэмж, хөдөлмөр эрхлэлт, газар эзэмших, ашиглахтай холбоотой асуудлаар ханджээ.


МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
88873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс:**
**976-70113551**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**


ШАР МЭДЭЭ

## УИХ-ын гишүүн урлагийн тоглолт хийх анхны тохиолдол бүртгэгдлээ


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Урлагийн тайзнаас улс төрд хөл тавьсан УИХ-ын гишүүн С.Жавхлан "Хамаг Монголын халуун сэтгэл" хэмээх тоглолтод оролцохоор болжээ. Тус тоглолтод УИХ-ын гишүүн С.Жавхлангаас гадна "Хамаг Монгол" төслийн дуучид оролцох юм байна. Энэхүү тоглолтоос олсон орлогыг ӨМӨЗО-ны дуучин, журмын нөхөр М.Баясгаландаа хандивлах аж. Учир нь дуучин М.Баясгалан өртөг өндөртэй, хүнд мэс засалд орохоор болсон тул их хэмжээний мөнгө хэрэг болжээ. Хандивын тоглолт 15 мянган төгрөгийн үнэтэй бөгөөд Монгол бөхийн өргөөнд энэ сарын 29, 30-нд болно. УИХ-ын гишүүн урлагийн тоглолт хийхээр болсон анхны тохиолдол нь энэ учраас тоглолт хийж болох эсэхийг заасан хуулийн заалт байдаггүй юм байна. Тиймээс энэхүү тоглолт хууль зөрчсөн үйлдэлд тооцогдохгүй аж. Хэрэв УИХ-ын гишүүн ашгийн төлөө тоглолт хийж, аж ахуйн нэгж удирдсан бол хууль зөрчсөн үйлдэл болдог байна. Ийнхүү Монгол Улсын Их Хурлын түүхэнд УИХ-ын гишүүн тоглолт хийж буй анх удаагийн тохиолдол болон бүртгэгдэж байгаа ажээ.

БАЙНГЫН ХОРОО

## Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулна

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны өчигдрийн хуралдаан 63.1 хувийн ирцтэйгээр эхэлж, "Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орох тухай" хуулийн төслүүдийг соёрхон батлах талаар болон Чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ. Байнгын хорооны хуралдаанаар эхлээд "Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орох тухай" хуулийн төслүүдийг соёрхон батлах асуудлыг хэлэлцсэн бөгөөд санал хураалт явуулахад, хуралдаанд оролцсон гишүүдийн 75 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхээр тогтлоо. Харин дараа нь Чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж, гишүүдийн 91.7 хувийн саналаар батлав. Бизнес эрхлэгчдийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, Монгол Улсыг гадаадад сурталчлах, гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах зорилтыг хэрэгжүүлэх, түүнчлэн дипломат албыг чадавхижуулах, зардал бууруулах зорилгоор Гадаад харилцааны яаманд зарим асуудлаар чиглэл өгөхөөр уг тогтоолын төсөлд тусгасныг гишүүд дэмжлээ. Харин УИХ-ын гишүүн Я.Санжмятав, Н.Оюундарь нар тогтоолын төсөлд найруулгын чанартай зарим засвар оруулах саналаа илэрхийлсэн юм. Дээрх асуудлын хэрэгжилтийг Байнгын хорооны ирэх оны эхний хуралдаанаар хэлэлцэхээр болов.

## Цэвэрлэх байгууламжийн ажлыг түргэвчлэхийг сануулав

УИХ ын Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар Туул голын бохирдлын асуудлаар ажлын хэсгийн мэдээллийг сонслоо. Ажлын хэсгийн танилцуулснаар нийслэл хотын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг бохир ус цэвэрлэх долоон байгууламж бүгд бохир усаа Туул гол руу нийлүүлдэг нь бохирдлын хамгийн том шалтгаан болдог байна.

Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал ус нийлдэг зургаан цооногоос мэргэжлийн байгууллагууд дээж авч судлахад хүн амын эрүүл мэндэд хортой хром, мөнгөн ус, зэс, цайр зэрэг хүнд металлуудын бохирдол маш өндөр гарчээ. Мөн Туул голын ай сав газар ашигт малтмалын олборлолт, хайгуул хийж буй аж ахуй нэгжүүд ч цөөнгүй байдгийг онцлов. Улмаар хуралдааны төгсгөлд УИХ-ын Өргөдлийн байнгын хорооноос Туул голыг тусгайлан хамгаалах, бохирдлыг бууруулах, цаашид бохирдлоос урьдчилан сэргийлэх, тодорхой эрх бүхий байгууллагад хариуцуулах, улсын тусгай хамгаалалтад авах чиглэлээр судлан, хууль бусад шийдвэрийн төсөл боловсруулан УИХ-д мэдүүлэх,

Төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн асуудал хэт удаашралтай байгаа тул шинэчлэлийн ажлыг шуурхайлах чиглэлд анхаарч ажиллах, нээлттэй тендэрийн шалгаруулалт явуулж, шинээр төв цэвэрлэх байгууламж барих ажлыг гүйцэтгүүлэх, Төв аймгийн Заамар сумын нутагт олгогдсон алтны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хуулийн хэрэгжилтийг хангуулах зэрэг 10 гаруй даалгаврыг Засгийн газарт өгөхөөр боллоо.

## ҮЗЭЛ БОДОЛ

# ЕРӨНХИЙ САЙДЫН ОРОН НУТАГ ДАХЬ ТОМИЛГООНД А ҮНЭЛГЭЭ ӨГЬЕ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Сэлэнгэчүүд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн түүчээ нь болж явах учиртай. Ирэх дөрвөн жилд манай зөгийчид дэлхийн зах зээлд байгалийн цэвэр, эко бүтээгдэхүүнээ гаргах зорилт тавин ажиллаж буй. Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын Япон улсад хийсэн албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд багтаж, хоёр улсын зах зээлийн харилцааны гүүрийг нь тавиад ирсэн.

Алтанбулагийн худалдааны чөлөөт бүсийг шинэ танил японaugчуудаа санал болгоод байгаа. Засаг даргын Тамгын газар Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвөө боловсруулаад дуусч байна. Ойрын үед ИТХ-д өргөн барьж, хэлэлцүүлнэ. Хөгжил дэвшил, орон сууцны шинэ хороолол, гэр хорооллын дахин төлөвлөлтийг ярьж болно. Харамсалтай нь, Дулааны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэхгүйгээр, шинээр барихгүйгээр юуг ч шийдэж чадахгүй. Хот төлөвлөлтөө шинээр хийнэ. Үүний төлөө би зүтгэх ёстой. Зүтгэх ч болно” хэмээн итгэл дүүрэн өгүүлж байсан. Улстөрчийн хувьд шинэ хүн байж болох ч нутаг усандаа хэдийнэ танигдсан, Сэлэнгэ аймгийн ИТХ-д сонгогдож байсан түүнийг Засаг даргаар томилогдох үед Ерөнхий сайдын халаасны нөхөр гэж ирээд л өөнтөглөж байсан ч түүнд хийе, бүтээе гэсэн чин хүсэл байгаа нь анзаарагдсаныг энд онцлон тэмдэглэх ёстой болов уу.

### “Хүн амаа өсгөж чадвал Дархан хот хөгжинө”

Социалист нийгмийн үед БНМАУ-ыг тэжээх үүрэг бүхий суурин газрыг байгуулсан нь найрамдлаар овоглосон Дархан хот. Эдүгээ 300 гаруй мянган хүн амтай энэ хотыг С.Насанбат засаглана. Тэрбээр өмнө нь тодруулбал, УИХ-ын 2012 оны сонгуулийн үр дүнд Засаг даргаар ажиллаж байсан нэгэн. Хүний хувьд ч зөөлөн гэгддэг ч улстөрчийн хувьд унаж, босч үзсэн толгой. Эрхэм Засаг дарга томилогдсон даруйдаа хотынхоо хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажилд ханцуй шамлан орсноо юун түрүүнд дурьдсан. Тэрбээр Дархан-Уул аймаг эдийн засгийн хувьд бие даасан чадвартай хот болох ёстой гэж үзэж байгаа аж. Үүний тулд нэн даруй хүн амаа өсгөх шаардлагатай гэнэ. Хоёр дахь алхам нь 10800 айлын нийтийн эзэмшлийн орон сууц барьж ашиглалтад оруулахаар төлөвлөж, ИТХ-аар батлуулсан байна. Харин үйлдвэржсэн гэх тодотголдоо эзэн нь байх тухайд “Дархан-Уул аймагт түлхэц хэрэгтэй байгаа. Үнэнийг хэлэхэд, гадны хөрөнгө оруулагчид орон нутагтай хамтран ажиллах сонирхолтой байдаг авч хууль, эрх зүйн талаасаа учир дутагдалтай байдаг. Тиймээс орон нутгийн удирдлагын эрх мэдлийг нэмэгдүүлж өгөх шаардлагатай байна. Орчин бүрдсэн байх аваас орон нутаг төсөв шүтгээд сууж байх асуудал үгүй болно” хэмээн нэгэнтээ өгүүлжээ.

### Цас сөргүүлэн давхих Н.Ганбямба

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Хэнтий аймгийн Засаг даргаар Н.Ганбямбыг томилох тухай аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн шийдвэрийг баталгаажуулсанаар энэ эрхэм төрж, өссөн нутаг руугаа хүлгийн жолоо залсан. 2016 оны УИХ-ын сонгуульд Хэнтий аймагт нэр дэвшихээр болж байсан тэрбээр нэр дэвшигчдийг тодруулах мөчид Т.Гантулгад өрсөлдөх боломжийг олгосноор Засаг даргад заларч суугаа нь энэ юм. МУИС-ийг түүхч, эдийн засагч мэргэжлээр, Москвагийн Нийгэм, эдийн засгийн дээд сургуулийг тус тус дүүргэсэн тэрбээр бусад засаг ноёдоос боловсрол, ажлын туршлагаараа тохой илүү нэгэн. Шулуухан хэлэхэд, аймаг түүнд жижигдэх улстөрч. УИХ-ын сонгуулийн дараа түүнийг Төрийн өмчийн хороо хавьд томилогдох байх гэсэн таамгийг цахим ертөнцийнхөн нэг хэсэг дэвшүүлсэн. Н.Ганбямба нь 2008-2012 онд УИХ-ын гишүүнээр сонгогдон ажиллаж байсныг нь уншигчид мартаагүй. УИХ-ын чуулганы нэгдсэн танхимд дуугүй суудаггүй, байнга л сахал нь хөдөлж суудаг гишүүдийн нэг байв. Ялангуяа, төсөвтэй холбоотой асуудал дээр өөрийн байр суурийг хамгаалж үлдэхдээ тун ч гаргуун байсан юм. Түүнийг санаачилсан, эхлүүлсэн, дуусгасан ажлаа нутгийн олондоо хэрхэн хүргэх тухайд учрыг нь түвэггүй олох нөхөр хэмээн хэвлэлийнхэн дүгнэдэг. Тэрбээр биднийг очиход өвөлжилтийн бэлтгэл ажил ямар байгааг малчны хот хэлээд өгнө хэмээн хамгийн их цас орсон гэх Дадал сум руу яваад ирээгүй байсан юм.

### 100 хоногт хороолол сүндэрлүүлсэн Засаг дарга

Дорноговь аймгийн Засаг даргаар Т.Энхтүвшин гэх шоволзсон бор залуу томилогджээ. Түүний намтар маш энгийн. Дорноговь аймгийн Сайншанд хотод төрсөн. Эрх зүйч, нягтлан бодогч мэргэжилтэй. Аймгийнхаа ЗДТГ-т Эдийн засаг, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, ЗДТГ-ын дарга, Мэргэжлийн хяналтын газрын дарга, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн мэргэжлийн хяналтын газрын дарга,нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын хэлтсийн даргаар ажиллаж байсан гэсхийгээд л төгсч. Хашиж явсан албан тушаалд нь дүгнэлт хийх аваас амьдрал мэдэхгүй нөхөр бишаж. Улстөрчийн хувьд бас ч гэж аймагтаа танигдсан нөхөр байна билээ. Дорноговь аймгийн МАН-ын хорооны даргаар 2005 оноос ажиллажээ. Тэрбээр улсын их баяр наадмын өмнөхөн тодруулбал, 2016 оны долдугаар сарын 08-нд тамгаа хүлээж аваад 18-аас ажлаа эхлүүлсэн байдаг. Улс төр гэх халуун тогоонд буцлаж, МАН-ын өвгөдийн ая эвийг нь олж сурсан түүнээс нэгэн сайхан чанар харагдсан нь аливаа ажлын ард гарахад улстөржилт хэрэггүй гэх зарчим. Мань эр Засаг дарга нараас хамгийн түрүүнд 100 хоногт хийж бүтээсэн ажлаа орон нутагтаа тайлагнасан сүрхий эр. Наадмын дара эхлүүлсэн орон сууцны шинэ хороолол нь дуусах дөхөж байна билээ. Мөн түүний санаанд хийж, бүтээхээр төлөвлөсөн олон ажил байгаагийн нэг нь Замын-Үүдийн чөлөөт бүсийн асуудал. Т.Энхтүвшин дарга чөлөөт бүсийг эдийн засгийн эргэлтэд оруулж, жинхэнэ чөлөөт бүс болгох суурь нь эхний ээлжинд үндэсний бүтээгдэхүүнүүдээ дэлгэх, худалдаалах 2-3 их дэлгүүрийг барьж ашиглалтад оруулах явдал хэмээн тодорхойлжээ. Түүнчлэн аялал жуулчлалын асар том зах зээлийг Дорноговь руу татахын тулд зөвхөн Эрээн-Замын-Үүд-Сайншанд-Хамрын хийд чиглэлийн аяллыг урд хөршийнхөндөө санал болгож, визийн асуудлыг шийдэх болно хэмээж байгаа нь өмнөх Засаг дарга нараа бодвол хөдөлгөөнтэй, овсгоотой эрийн шинж биз ээ.

### “Говьсүмбэр Сүхбаатар шиг хөгжинө”

Монгол Улсын хамгийн цөөхөн сумтай аймгийг тодруулбал, Говьсүмбэрийг Г.Батсуурь засаглаж байгаа. Дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, их хөлийн суурин гэж хэлж болох Говьсүмбэр аймаг хөгжлөөрөө муугүй. Чойр хайрханаа эдийн засгийн эргэлтэд оруулж, Хамрын хийдийг зорих аялагчдыг замд нь хүлээн авдаг болно хэмээн ИТХ-ын дарга Г.Батзам ярьж байсан нь чухамдаа Засаг даргынх нь санаа байсан юм билээ. Гомбодоржийн Батсуурь нь 2012 оны орон нутгийн сонгуулийн дараа Говьсүмбэр аймгийн Засаг даргаар сонгогдсон ч харамсалтай нь тухайн үеийн Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг батламжлаагүй. Гэсэн хэдий ч 2015 онд аймгийн ИТХ-ын даргаар сонгогдсон, аймгийн МАН-ын хорооны даргын сонгуульт албыг хашиж байсан гэхээр нутаг усандаа нэр хүндтэй нэгэн байж таарч байгаа юм. Улстөрчийн хувьд буурьтай, хэдийд дуугарахаа мэддэг тэрбээр Говьсүмбэр аймгаа Сүхбаатар аймаг шиг хөгжүүлнэ хэмээн нутгийн иргэддээ амласан юм гэнэ лээ. Зам нь, хил нь ойр түүнд аймгаа хөгжүүлэх боломж ойрхон буй. Тэрбээр наадмын өмнөхөн томилогдсон Засаг дарга нарын нэг. ШУТИС, Удирдлагын академийг тус тус дүүргэсэн тэрбээр ажлынхаа гарааг аймгийнхаа Нефть хангамжийн газрын засварчнаар эхлүүлж, улмаар ерөнхий инженер, даргаар ажиллах хүртлээ өсч дэвшжээ. Г.Батсуурь 2006-2010 онд Говьсүмбэр аймгийн Засаг даргын орлогч, 2012 оноос МАН-ын хорооны дарга, 2015-2016 онд Говьсүмбэр аймгийн ИТХ-ын дарга зэрэг албыг хашсан туршлагатай нэгэн аж.

### Сумын Засаг даргаас аймгийн Засаг дарга

Ажлаа мэддэг, иргэдийнхээ амьдрал руу өнгийж чаддаг хүний зангараг Батжаргал Засаг даргатай уулзсан даруйд анзаарагдах юм билээ. Ерөнхий сайдын хамгийн түрүүнд батламжилсан гурван аймгийн Засаг даргын нэг нь Ж.Батжаргал. Сумын Засаг даргаас улс төрийн албан тушаалын сайн муу, сайхан муухайг анх мэдэрсэн тэрбээр албан тушаалын хувьд өсч өндийж явсаар эдүгээ Төв аймгийн Засаг даргаар ажиллаж буй. Өнгөрсөн 2014-2016 оны сонгуулийн дараа Ж.Батжаргалыг аймгийн ИТХ-ын даргаар томилсон байдаг юм. Өмнө нь аймаг удирдалцаж явсан хүний хувьд түүний оюун бодолд аймгийнх нь хөгжил, дэвшил багтаж байгаа нь мэдээж. Улсынхаа нийслэлийг нутаг дэвсгэртээ багтааж байгаагийн хэргийг, сая илүү хүн амтай их хотын хүнсний хэрэгцээг хангаж гаргана хэмээн тодорхойлжээ.

Дугаарын **60** мөр

## Бага ангийн сурагчдыг амраая

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэр дундаа бага ангийн сурагчид эрүүл мэнд, цаашлаад амь насаараа ч хохирох болов. Учир нь ГССҮТ-д өдөрт 300 орчим хүн ханддагаас 70 орчим хувийг нь зөвхөн хальтирч унаад хөл, гараа хугалан бэртэж гэмтсэн хүмүүс эзлэх болсон гэнэ. Ялангуяа эмнэлгийн хүлээн авахад ирж буй иргэдийн ихэнх нь хүүхдүүд байгааг ч эмч, мэргэжилтнүүд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэлээд буй. Нөгөөтэйгүүр зам, талбай хальтиргаа гулгаа ихтэй үед зам тээврийн осолд ихэвчлэн хүүхэд өртөх нь ихэсчээ. Өнгөрсөн мягмар гарагт л гэхэд Toyota Prius-20 автомашины жолооч дунд сургуулийн сурагч есөн настай А, 13 настай Б нарын хоёр хүүхдийг мөргөж, гэмтээсэн байх юм. Энэ мэтчилэн нөгөө л хальтиргаа, гулгаатай замын хохирогч нь багачууд болж байна. Хүн бүр хүүхдээ асран хамгаалах, эрүүл аюулгүй орчинд амьдруулах үүрэгтэй. Тэгвэл энэ үүргээ ухамсарлаад ядаж бага ангийн сурагчдаа амраая. Тэртэй тэргүй хот өөрийн нөөц дэх сүүлийн 100 тонн давс, бодисоо цацахаа мэдэгдчихсэн юм чинь. Хэрэв үнэхээр нийслэлийн хэмжээнд давс, бодис цацахаа больчих юм бол цаашид гудамж талбай, машин зам ямар болох нь ойлгомжтой. Одоо байгаагаасаа ч илүү дордоно гэсэн үг. Тэр үед бид мянга хүрз бариад ч мөснөөсөө салж дийлэхгүй биз. Ус, цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс ч 100 жилд тохиогоогүй хүйтэн өвөл болно хэмээн анхааруулга, сэрэмжлүүлэг хүргэсэн. Энэ мэдээллээс харахад ес эхлэхээр улам л их цас орж, хүйтрэх нь тодорхой. Тэгэхээр гарч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж ядаж бага ангийн сурагчдыг амраая л даа. Ингээд бичихээр зарим хүмүүс “Юун сүртэй юм бэ. Манай улсад жил бүр л хүйтэн болж байдаг. Хүүхдүүд сургуульдаа явж л байдаг шүү дээ” хэмээн тайлбар хэлж магадгүй. Гэхдээ шөнөдөө -35 хэмээс хол давж байгаа нь бидний нүдэн дээр л ил байна. Нэгэн жишээ дурьдахад л нийтийн тээврийн 54 автобус хөлдсөн талаархи мэдээлэл сошиал ертөнцөд хөврөх болсон. Энэ нь ч үнэний ортой. Сүүлийн үед оройн 17:00 цагаас хойш нийслэлд нийтийн тээврийн үйлчилгээ зогссон гэхэд нэг их үнэнээс хол зөрөхгүй. Иргэд бараг 1-2 цаг гаруй буудал дээр хацар, амаа хайруулан байж автобусанд сууж байна. Хүлээлгэж, хүлээлгэж ирсэн автобус нь пиг дүүрэн хүнтэй, зарим нэг нь хүмүүсээ ч бүтэн суулгалгүй хаалгаа хааж аваад давхих нь энүүхэнд. Тэгээд л багталгүй үлдэж хоцорсон хүмүүс дараагийн автобусыг иртэл дахиад цаг гаран хүлээнэ. Хамгийн гол нь тэр хүлээж буй хүмүүсийн дунд арван жилийн сурагчид олон байна гэдгийг энд онцолмоор байна. Тэр дундаа зарим бага ангийн сурагчдын хичээл өдөр орох нь бий. Мэдээж өдөр орсон ангиуд оройн 18:00 цагаас хойш тарна. Тэгээд л хальтирч унаж, хөл, гараа бэртээхээс эхлээд л машин доогуур орчих шахам байж автобусны буудал дээр иртэл явах унаа ч байхгүй орчинд л хүүхдүүд амьдарч байна. Олны олон дотор янз бүрийн амьдралтай, сэтгэхүйтэй хүмүүс бий. Зарим нь машинтайгаа ирээд хүүхдээ аваад явж байхад, зарим нь машингүй хэрнээ хүүхдээ аваад хар хүйтэнд нийтийн тээвэр хайгаад явж байна. Зарим нь бүр хүүхдээ ч авахгүй, хүүхдүүд нь өөрсдөө гэртээ харьж байх жишээтэй. Гэхдээ хүүхдүүд өөрсдөө гэртээ харьж байгаа нь олон болов уу. Хөдөө орон нутгийн сургуулийн хүүхдүүд ямар замыг туулан сургууль, цэцэрлэгийн бараа харж байгаа нь бүр ч ойлгомжтой биз. Бидний нүдэн хүүхдүүд ямар хүнд, хэцүү нөхцөлд сургуульдаа явж буй нь илт байхад бага ангийн сурагчдаа амраавал дээргүй юу. Хэзээ хойно нь харамсаж суухын оронд өмнө нь урьдчилан арга хэмжээ аваач, БСШУС-ын сайд аа.

Угаасаа зуны дэлгэр цагт олон сар амраадаг юм чинь түүнээсээ нэг сар сунгаж хичээлүүлээд, одоо ид хүйтэн 12-1 сар гартал амраачихвал аятай юу.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УЛС ТӨР

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

# Д.ЭРДЭНЭБАТ: АН-ЫН ЛИДЕРҮҮДИЙГ НЭГ НЭГЭЭР НЬ БАРИВЧИЛЖ БУЙ АСУУДЛААР ҮНДЭСЛЭЛТЭЙ МЭДЭЭЛЭЛ ЦАЦНА




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

...Н.Алтанхуяг даргын хэлж байгаа байр суурь бол хувь хүнийх гэж ойлгох хэрэгтэй. Би дахиад хэлье. Зөвхөн Н.Алтанхуяг гэдэг хүндээ биш, АН-ын лидерүүдийг нэг нэгээр нь бодлоготойгоор асуудалд холбогдуулж байгаа нь буруу. Тиймээс АН-аас энэ асуудалтай холбоотойгоор үндэслэлтэй мэдээлэл гаргаж, олон нийтэд таниулах зайлшгүй шаардлагатай байгаа...

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

**-Ажлын хэсгийн ахлагчийн хувьд намын их хуралд оролцох төлөөллийг хэрхэн сонгох гэж байгаа талаар мэдээлэл өгөөч?**

-Ажлын хэсгийн ажил шуурхай явж байгаа. Учир нь бидэнд хугацаа бага үлдсэн. Тиймээс ч ажлын хэсэг хуралдаад гүйцэтгэх зөвлөлөөрөө их хуралдаанд оролцох төлөөлөгчдийг сонгох журмаа батлуулуулаад өнөөдөр /өчигдөр/ олон нийтэд мэдэгдэж байна. Төлөөлөгчдийг сонгох журмын дагуу бүх орон нутгийн намын анхан шатны байгууллагаас буюу сум бүрээс нэг төлөөлөгч байна. Аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд АН-аас сонгогдсон төлөөлөгчид, ҮЗХ-ны гишүүд, Хяналтын ерөнхий хорооны гишүүд, намын дэргэдэх байгууллагуудын төлөөлөл гэсэн бүтэцтэйгээр хуралдахаар журамдаа тусгасан. Нийтдээ 1210 төлөөлөгч их хуралд оролцохоор болсон гэсэн үг. Төлөөлөгчийг сонгох журам буюу манай өнөөдөр мөрдөгдөж байгаа дүрмээр анхан шатны байгууллагууд хуралдаж, сум болон нийслэлийн хороодоос намын их хуралд сонгогдох төлөөлөгчдөө сонгож явуулна. Мэдээж энэ үйл ажиллагаа өрсөлдөөний зарчмаар явна. Маргааш /өнөөдөр/ бид хэвлэл мэдээллийн хэрэгслээр журмынхаа дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх болно.

**-Намын анхан шатны байгууллагын хурал хэзээ болох вэ. Уг хурлаар зөвхөн их хуралд оролцох төлөөлөгчөө л сонгох уу, эсвэл?**

-Намын анхан шатны байгууллагын хуралдааныг энэ сарын 26-27-ны хооронд хуралдах товыг өнөөдөр / өчигдөр/ гүйцэтгэх зөвлөл тогтоолоо. Тиймээс төлөөлөгчид маань энэ долоо хоногийн бямба, ням гарагт анхан шатныхаа намын үүрийн хурлыг хуралдуулж, төлөөлөгчөө сонгох шаардлагатай. Энэхүү анхан шатны хуралдаанаар хоёр асуудлыг голчлон хэлэлцэх ёстой гэж үзэж байгаа. Нэгдүгээрт, үндсэн дүрмийн шинэчлэлийн хэлэлцүүлгийг хийх учиртай. Хоёрдугаарт, намын VI их хуралд сонгогдох төлөөлөгчөө сонгох үйл явц болно.

**-АН-ын дарга асан Н.Алтанхуяг Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх гэж байгаагаа мэдэгдсэн. Түүний нэр дэвших гэж байгаа нь намаас хамааралтай гаргасан шийдвэр мөн үү?**

-Ерөнхийлөгчийн сонгуулийн сунгаа явагдаад эхэлчихсэн. Н.Алтанхуяг гишүүний хувьд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээ илэрхийлдэг нь хувь хүний л асуудал. Тиймээс бид ямар нэгэн хориг, саад тавьж болохгүй. Мэдээж АН-аас нэр дэвшихээр горилж байгаа хүн нэг биш байгаа. Та бүхэн санаж байгаа байх. 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийг албан ёсоор сунгаа хэлбэрээр дотооддоо зохион байгуулж байсан. Улмаар зургаан нэр дэвшигч тодорч байлаа. Түүнээс эцсийн байдлаар ҮЗХ-гоороо шалгаруулаад, Их хурлаараа оруулсан. Тэгвэл энэ удаад ч гэсэн зарчмаараа явна гэж ойлгож болно. Ер нь олон нийт болоод манай намын гишүүдийн хүслээр АН-ын шинэчлэлийг маш шуурхай хийж, нэг тийш нь болгох ёстой гэдэг дээр бүгд санал нэгдэж байгаа. Шинэчлэлийн асуудал дээр ямар нэгэн эргэлзээ байхгүй. АН хэрхэн шинэчлэгдэх, хэр зөв зохион байгуулалттай болох эсэхээс хамаарч Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнд нөлөөлнө гэж харж байгаа.

**-Намын дарга Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихгүй байхаар яригдаж байгаа гэсэн?**

-Үндсэн дүрмийн шинэчлэлийн хүрээнд яригдаж буй нэг зүйл нь намын дарга Ерөнхийлөгчид нэр дэвшихгүй байх нөхцөл тусгагдаж байгаа. Бид үүнийг хаа хаанаа дэмжих хэрэгтэй. Намын дарга гэдэг бол дөрвөн жил намыг тогтвортой авч явах, бодлогын хувьд зүтгүүр нь болох, намын тэргүүн буюу гол менежер байх ёстой гэсэн зарчим руу АН-ын үндсэн дүрмийн шинэчлэлийн гол утга санаа явж байгаа.

**-Энэ удаагийн сонгуульд АН-ыг ялагдалд хүргэсэн хүмүүст хариуцлага тооцох асуудал яригдаж байсан. Энэ их хурлаар уг асуудал яригдах болов уу?**

-Хариуцлагын тухай асуудлыг сая ҮЗХ хуралдаад, Их хурлаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн. Гэхдээ гишүүдэд зарчмын зөрүүтэй санал байсан гэдгийг үгүйсгэхгүй. Түүнчлэн нэгэнт ҮЗХ-ны олонхи энэ асуудлыг шийдэх шаардлагагүй гэж үзсэн болохоор хариуцлагын асуудал яригдахгүй гэсэн үг. Харин намынхаа шинэчлэлийг хэрхэн хурдан хийх вэ гэдэг асуудалд төвлөрөөд ажиллах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа.

-Ойрын өдрүүдэд Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийг тойрсон маш олон баривчилгаа явагдаж байна. АН-ын дарга байсан хүний хувьд өмгөөлж, хамгаалах асуудал яригдаж байна уу?

-Энэ асуудал нам дээр нэлээд өргөн хэлэлцэгдэж байгаа. Зөвхөн Ерөнхий сайд байсан хүний тухай асуудал биш. АН-ын, хуучин ажиллаж байсан лидерүүдийг нэг нэгээр нь янз бүрийн шалтгаанаар буюу үндэслэлтэй, үндэслэлгүй мэдээллийн дагуу баривчлан саатуулж байна. Түүнчлэн олон нийтэд муухай харагдуулах, сенсаации дэлгэх гэсэн асуудал дээр манай гишүүд үнэхээр санал нэгдэхгүй байгаа. Тиймээс ойрын хугацаанд АН энэ тал дээр байр сууриа илэрхийлэх ёстой.

**-Н.Алтанхуяг намын дотоод зөрчил буюу фракцийн асуудалд Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг гар бие оролцоод байна гэдэг зүйлийг яриад байгаа. Энэ асуудал дээр намын зүгээс тайлбар өгөх үү?**

-Н.Алтанхуяг даргын хэлж байгаа байр суурь бол хувь хүнийх гэж ойлгох хэрэгтэй. Би дахиад хэлье. Зөвхөн Н.Алтанхуяг гэдэг хүндээ биш, АН-ын лидерүүдийг нэг нэгээр нь бодлоготойгоор асуудалд холбогдуулж байгаа нь буруу. Тиймээс АН-аас энэ асуудалтай холбоотойгоор үндэслэлтэй мэдээлэл гаргаж, олон нийтэд таниулах зайлшгүй шаардлагатай байгаа.

**-Үндсэн дүрмийн шинэчлэлд намын даргыг сонгох асуудлыг шинээр оруулж өгсөн үү. Ерөнхийдөө нэлээд олон зүйл яригдаж байгаа сурагтай байсан?**

-АН-ын дүрмийн шинэчлэлийн асуудлаар олон зүйл хөндөгдөж байгаа. Энэ асуудлаар VI их хуралд бэлтгэх үндсэн дүрмийн ажлын хэсгийнхэн тусгайлан мэдээлэл хийхээр тохиролцсон. Тиймээс тусдаа мэдээлэл хийнэ гэж ойлгох хэрэгтэй.

**-АН фракцигүй болох асуудал үндсэн дүрэмд тусгагдсан уу. Энэ асуудлаар аймгуудаас санал хүсэлт ирж байгаа юу?**

-Ер нь фракцигүй байна гэдэг асуудлыг бид нэг талаас нь хэт өрөөсгөл ойлгож болохгүй. Мэдээж хувийн ашиг сонирхол, эрх мэдлийн төлөө нэгдсэн фракци байхгүй байх ёстой гэдэг дээр миний бие хүртэл санал нэг байгаа. Хаа ч газар байдаг нэг зүйл нь юу вэ гэхээр бодлогын хэмжээнд гишүүд буюу санал нэгдсэн хүмүүс бүлэг, хэсэг байгуулаад асуудалд ханддаг. АН-ын дүрмийн шинэчлэлийн хүрээнд албан ёсны ашиг сонирхлын фракцийг байлгахгүй байх тухай асуудлаар үндсэн дүрэмд тусгагдаад явж байгаа. Нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Бид улс орны хөгжлийн төлөө нэгдэж ажиллахдаа бодлогын хэмжээнд нэгдсэн нам байх ёстой болохоос хэн нэгэн хүнийг дагасан ашиг сонирхолдоо нэгдсэн бүлэглэл байхыг тэвчих ёсгүй гэдэг дээр санал нэг байгаа.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## У.Хүрэлсүх сайд БНХАУ-д айлчлах эсэх нь тодорхойгүй байна

Монгол, Хятад хоёр улсын Засгийн газар хоорондын хуралдааныг энэ сарын 29-ний өдөр БНХАУ-д хийхээр товлосон. Энэ хуралдаанд Монгол Улсыг төлөөлж Шадар сайд У.Хүрэлсүхээр ахлуулсан ажлын хэсэг урд хөрш рүү явахыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэсэн. Гэвч БНХАУ-ын тал Дээрхийн гэгээнтэн XIV Далай ламын айлчлалтай холбоотойгоор Шадар сайд У.Хүрэлсүхийн айлчлалыг цуцалсан тухай мэдээлэл цацагдаж эхэллээ. Тэгэхдээ Гадаад харилцааны яаманд одоогоор албан уулзалтыг цуцалсан тухай албан бичиг, нот огт ирээгүй гэдгийг тус яамнаас онцолсон. Харин У.Хүрэлсүх сайдын хэвлэлийн албанаас дээрх асуудлыг тодруулахад “БНХАУ руу ямар нэгэн айлчлал, уулзалт хийнэ гэсэн тов одоогоор гараагүй байгаа” хэмээн тайлбарласан юм. Албаны эх сурвалжуудын өгч буй тайлбараас үзэхэд хоёр улсын Засгийн газар хоорондын хуралдааныг цуцлаагүй, харин уг хуралд Шадар сайд оролцох эсэх нь тодорхойгүй байгаа аж.

## Ажлын хэсгийн гишүүд Сонгинохайрхан дүүрэгт ажиллав

УИХ-ын гишүүн Х.Нямбаатар, М.Оюунчимэг, Д.Цогтбаатар нар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын байдалтай танилцахаар нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт ажилласан байна. Өнгөрсөн парламентын үед Монгол Улсын Ерөнхийлөгч Эрүү болон Зөрчлийн багц хуулийг УИХ-д өргөн барьсан бөгөөд үүнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль багтсан байсан билээ. Гэвч энэхүү багц хуулийг энэ парламент хэлэлцээд буцаасан юм. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулиудын төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай тогтоолыг гаргаж, ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Н.Оюундарийг томилсон. Тиймээс ажлын хэсэгт багтсан дээрх гишүүд Сонгинохайрхан дүүргийн хороодын нийгмийн ажилтан, цагдаагийн хэлтсийн албан хаагчидтай уулзалт хийж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зорилтыг танилцуулахын зэрэгцээ шинэчилсэн найруулгын төсөлд санал авчээ. УИХ-ын гишүүн Х.Нямбаатар хэлэхдээ, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг ирэх долоо хоногт Хууль зүйн байнгын хороогоор оруулж, улмаар чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Хэдийгээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2004 онд батлагдсан хэдий ч энэ хуулийн зохицуулалт оновчтой бус байгаа тул Ажлын хэсэг газар дээр нь ажиллах, та бүхний саналыг тусгах, энэ хуулийг бүх талаас нь дэнслээд шинэчилсэн байдлаар оруулж ирж байна хэмээсэн байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# ДАЛАЙ ЛАМ: Х Богдыг 4-5 нас хүрэх үед олонд зарлаж, сэнтийд нь зална

Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Монгол Улсад энэ сарын 18-23-ны өдрүүдэд номын айлчиллаа. Айлчлалынхаа төгсгөлд “Их тэнгэр”-т хэвлэлийн бага хурал зарлан, сэтгүүлчидтэй уулзсан юм. Хурлын эхэнд Далай лам, “Монгол Улсад дахин айлчилж байгаадаа би маш их баяртай байна. Би аль ч улсад айлчилсан хамгийн эхний үүрэг хариуцлага маань дэлхийн энх тайван, амар амгаланг тогтоох байдаг. Дэлхий дээр долоон тэрбум хүн байдаг. Тэд зовлонг эс хүсч амар амгаланг хүсдэг. Гэвч зовлонгийн шалтгаан нь уур хилэн, хүсэл, шунал юм.

Энэ уур хилэн, хүсэл шуналыг дарах арга бий. Амар амгаланг бий болгодог зүйл бол бусдыг энэрэхүйн сэтгэл, асран хамгаалах юм. Шинжлэх ухааны үүднээс үзсэн ч гэсэн амар амгалан байх үндэслэл бий. Хүмүүний мөн чанар амар амгаланг хүсдэг. Дэлхий дээр олон төрлийн шашин бий. Бурхны номонд асархуйн сэтгэл, энэрэхүйн сэтгэлийг дэлгэрүүлэх хэрэгтэй гэж бурхны сургаальд айлдсан байдаг. Бүх шашин асрахуйн сэтгэл, энэрэхүйн сэтгэлийг айлдсан. Эдгээр олон шашин эв нэгдэлтэй байх нь чухал. Хүний бодол, санаа өөр хоорондоо ялгаатай байдаг болохоор үзэл сургааль нь өөр өөр болох нь гарцаагүй юм. Монгол, Түвд орны хувьд 3000 жилийн өмнөөс холбоотой, барилдлагатай байсан ард түмэн. Түвдийн шашин дэлгэрэхээс өмнө ч бид холбоотой байсан болов уу. Хүний төрлөөр нь аваад үзвэл монгол хүүхэд төрөхдөө хондлой дээрээ хөх толботой төрдөг шиг түвд хүүхдүүд ч тийм толботой төрдөг. Бид үүгээрээ адилхан. Шашин, соёлоор нь аваад үзсэн ч азиудад адилхан зүйл олон байжээ. Монгол оронд шашин шүтэх, шашны ном үзэх хориотой байсан ч өнөөдөр сайхан цаг ирсэн. Та бүхэн их хичээл, зүтгэл гаргаж байгаад талархаж явдаг шүү. Мэргэдийн дамжуулж ирсэн номыг сүм, дуган барьснаар, хурал хурснаар авч явахад хэцүү. Гол нь суралцах хэрэгтэй. Эртнээс хэлж ирсэн үгээ одоо ч хэлье. Та бүхэн номд сайн суралцаарай гэдгийг дахин дахин хэлье” гэв. Энэ үеэр сэтгүүлчид IX Богдын хойд дүрийг тодруулсан эсэхийг хамгийн их сонирхон асуусан. Энэхүү асуултад тэрбээр, “Х Богд Монгол Улсад мэндэлсэн. Гэхдээ одоо нялх байгаа учраас энэ талаар ярихад эрт байна. 2-3 жилийн дараа буюу 4-5 нас хүрэх үед нь олонд зарлаж, сэнтийд нь зална” хэмээн хариулсан юм. Мөн хэвлэлийнхэнд хандан Гандантэгчинлэн хийдийн хамба лам Д.Чойжамц “Далай багш маань ес дэх удаагаа Монголд ирж байна. Энд ямар нэгэн улс төрийн зорилго байхгүй. Цэвэр шашны ажлаар Монголын сүсэгтэн олон, лам хуваргуудын урьсны дагуу ирсэн. Энэ хугацаанд олон түмэндээ айлдсан сургаалийг нь та бүхэн маань сонссон. Энэ бүхэн Монголын ард түмний эв нэгдэл, нягтрал, сайн сайхныг талаар байсан. Монголчууд төдийгүй дэлхий нийтийн сайхан сайхны төлөө айлдвар айлдлаа” гэдгийг онцолж байв. Ийнхүү хэвлэлийн хурал хийсний дараа Дээрхийн гэгээнтэн XIV Далай багшийг Гандантэгчинлин хийдийн Тэргүүн их хамба лам, гавж Д.Чойжамц тэргүүтэй лам хуваргууд үдэн гаргаж өгсөн юм.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# ОНЦЛОХ ХУУДАС

## Õýí íü õýí áý?



# МЭРГЭЖЛИЙН САЙД

Н.ПУНЦАГБОЛД

"Монголын мэдээ" сонин "Мэргэжлийн" Засгийн газрын сайдуудыг "Хэн нь хэн бэ" булангаараа онцолж байгаа билээ. Энэ удаагийн дугаартаа БХБ-ын сайд Г.Мөнхбаярыг онцлон хүргэж байна.

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

...Г.Мөнхбаяр сайд энэ хоёр салбарт хоёуланд нь насаараа зүтгэсэн хүн. Тиймээс туршлагын тухайд түүнтэй яриад байх юм байхгүй. Одоо хамгийн гол нь зөв менежменттэй, төлөвлөлттэй, хамгийн гол нь сэтгэлтэй л ажилламаар байна. Ямар хотын онцлогоо мэдэхгүй гэх биш. Юу шаардлагатай вэ, яаж ажиллавал зүгээр, аль хавийг дэд төв болгох вэ гэдгийг хэнээр ч хэлүүлэлтгүй мэдэж байгаа...

### Мэргэжлийн бус Засгийн газрын мэргэжлийн сайд

МАН-ынхан сонгуулийн өмнө хэрвээ ялалт байгуулбал мэргэжлийн Засгийн газар байгуулна гэж амласан. Тэгээд тэд ялсан. Ялах ялахдаа өрсөлдөгчөө далаар нь цэвэр савсан. Харин ялсныхаа дараа яасан билээ. Мэргэжлийн гэж тодотгосон Засгийн газар нь тодорхойлолтоосоо нэлээд холуур зөрсөн нь үнэн. Тэгвэл энэ Засгийн газарт байгаа цөөн хэдэн гайгүй сайдын нэг нь Г.Мөнхбаяр. Түүнийг мэргэжлийн сайд гэж тодотгосон нь ч учиртай. Тухайлбал, Эрүүл мэндийн сайдаараа Анагаахын сургуульд суралцаж төгсөөд, дараа нь шат шатны эмнэлэгт ажиллаад, эмчийн зовлон, жаргалыг туулсан. Сайн ажилласныхаа хүчинд бага багаар албан тушаал ахиж явсаар том эмнэлгийн дарга болсон, энэ салбарын бүхий л нарийн ширийнийг мэддэг, эмч нараа ч, өвчтөнөө ч ойлгодог хүний томилбол тун сайн хэрэг биз дээ.

Хамгийн гол нь иим хүн Эрүүл мэндийн салбарыг өөд нь татаж босгохын төлөө сэтгэлээ гаргаж ажиллаж чадна. Хөдөө аж ахуйн салбарт ч гэсэн сайн менежер, тэгээд энэ чиглэлээрээ сургууль соёл төгссөн, ажиллаж байсан хүнийг тавьбал сайн хэрэг. Энэ мэтээр салбараа мэддэг, ойлгодог. Хамгийн гол нь тэр салбарын төлөө сэтгэлээ чилээдэг хүн сайдаар ажиллах хэрэгтэй байгаа юм. Үүнийг л Мэргэжлийн Засгийн газар гэж нэрлэх учиртай биз дээ. Гэтэл өнөөдөр БХБ-ын сайдаас өөр яг иим мэргэжлийн сайд байгаа бил үү, үгүй. Г.Мөнхбаяр гэдэг хүнийг монголчууд нийслэлийн Засаг дарга байхаас нь мэднэ. За тэр Засаг даргаар ямар ажилласан бэ гэдгийг нь яривал янз бүрээр л харьцуулагдах байх. Харин Барилгын салбарын сайд хийхийн хувьд бол нүдээ олсон гэж хэлэхэд болно. Тэрбээр 1984-1989 ОХУ-ын Свердловск хотын Уралын Политехникийн их сургууль, 1995-1997 Монгол Улсын Техникийн их сургууль төгссөн. Монгол Улсын зөвлөх инженер хүн. 1989-1990 онд НААҮЯ-ынтуршилт тохируулгын ангид техникч, 1990-1991 ОСНАА-н зургадугаар конторын инженерээр ажиллаж байсан нэгэн. Ерөөсөө энэ салбарт хамгийн ойрхон хүн гэж ойлгож болно.

Тиймдээ ч энэ салбарт тулгамдаад байгаа олон асуудлыг шийдэх чадвартай гэж харж, найдаж, хүлээж байна. Дахин төлөвлөлтөөс авахуулаад одоо зах зээл дээр зарагдахаар бэлэн болчихоод байгаа орон сууцнуудыг яах вэ гээд шийдэх асуудал маш их байна. Дээрээс нь барилгын компаниудын өр зээлийн асуудал ч том сэдэв болчихоод байгаа. Тэр бүхнийг мэргэжлийн талаас нь харж, зохицуулж, өмнө нь гарч байсан алдаатай бодлогуудыг засч, ард түмэнд хэрэгтэй ажил хийх болов уу ч гэж харж байна.

### Төрийн албанд ажилласан туршлагатай

1990-ээд оны цаг үеийн өөрчлөлт, шинэчлэлтийн үед НААҮЯ-нд туршилт тохируулгын ангид техникч хийж, төрийн албаны ажлын гараагаа эхэлсэн нэгэн. Улмаар 1990-1991 онд Найрамдал дүүргийн орон сууц нийтийн аж ахуйн зургадугаар дугаар конторт жирэмсэн эмэгтэйн оронд техникч, инженерээр ажиллаж байсан түүхч түүнийх. Тэрбээр орон сууцны конторт инженерээр ажиллаж байгаад жилийн дараа Орон сууцны удирдах газарт дэвшив. Гурван жилийн дараа ерөнхий инженер болж мөн л гурван жилийн дараа Газрын дарга гэж дуудуулах болжээ. Харин 2004 оноос Улаанбаатар хотын ерөнхий менежер, 2008 оноос Улаанбаатар хотын Захирагч, нийслэлийн Засаг дарга болсон. Түүний ажилласан түүхийг харахад, төрийн албанд залуугаасаа эхлээд л ажиллаж байсан нь харагдана. Өнөөдөр Монголд төрийн алба гэдэг ердөө л наймааны хэрэгсэл болчихоод байгаа гээд хэлчихэд буруудахгүй. Даргын суудал бүр үнэлгээтэй болчихсон. Эсвэл хэн нэгэн цүнх барьж гүйсэн залуугийн шагнал болж хувирчихаад байгаа. Тиймдээ ч энд тэнд томилогдож очиж байгаа дарга нар нь салбараа мэдэхгүй, төрийн албанд ганц ч хоног ажиллаж байгаагүй, зүгээр л нэг бизнесмэн, эсвэл "шалдан гуя" байх нь олон. Уг нь бол байгууллагын шинэ цэрэг, хуушуур, буузанд гүйдэг зарлага байхаасаа эхлээд хэлтсийн даргаар дамжаад цаашаа өгсөх учиртай. Тэгж байж л жинхэнэ сэтгэлтэй, салбараа мэддэг, салбарынхнаа ойлгодог дарга нар төрж гарна. Дээрээс нь төрийн алба гэдэг ямар хариуцлагатайг ухамсарласан, ард иргэдээ ойлгодог дарга нар гарч ирэх учиртай. Гэтэл одоо бол нөхцөл байдал огт өөр болчихсон. Тухайн салбарын талаар номноос уншаагүй нөхөр дарга болчихоод байна.

Төрийн албанд ганц өдөр ажиллаагүй, наймаачин "гар" сайд, дарга болдог. Тэр бүхэнтэй жишихэд бол БХБ-ын сайд насаараа төрийн албанд ажиллажээ. Тэр дундаа Улаанбаатар хотын захиргаанд хотын менежер, нийслэлийн засаг дарга гээд хариуцлагатай албыг хашиж, зовлон жаргалыг нь эдэлж явсан учраас юу л байна, туршлага байгаа. Дээрээс нь барилгын салбарынх. Тийм болохоор БХБ-ын сайдад тун ч сайн зохицохоор. Өнөөдөр Барилгын салбарын тухай ярихаар л нийслэлийн асуудлуудыг давхар хамруулах болдог. Улаанбаатар хотыг утаанаас, хөрсний бохирдлоос салгахын тулд орон сууцжуулах хэрэгтэй. Цаашлаад гэр хорооллыг дахин төлөвлөх, төвийн шугамд холбох. Хотын дэд төвүүдийг барьж, иргэд тухайн бүсээсээ гарахгүйгээр төрийн бүх үйлчилгээг авдаг болох хэрэгцээ шаардлага ч манайд тулгарч байгаа. Энэ бүхнийг нэн даруй шийдэх цаг болсон. Тэгвэл энэ ажлыг хийж хэрэгжүүлэхэд Улаанбаатар хотыг мэддэг, дээрээс нь барилгын салбарын жаргал, зовлонг ойлгодог хүн хэрэгтэй биз дээ. Тэгвэл Г.Мөнхбаяр сайд энэ хоёр салбарт хоёуланд нь насаараа зүтгэсэн хүн. Тиймээс туршлагын тухайд түүнтэй яриад байх юм байхгүй. Одоо хамгийн гол нь зөв менежменттэй, төлөвлөлттэй, хамгийн гол нь сэтгэлтэй л ажилламаар байна. Ямар хотын онцлогоо мэдэхгүй гэх биш. Юу шаардлагатай вэ, яаж ажиллавал зүгээр, аль хавийг дэд төв болгох вэ гэдгийг хэнээр ч хэлүүлэлтгүй мэдэж байгаа. Тэртэй тэргүй хотын даргаар ажиллаж байхдаа энэ бүхэнд сэтгэлээ чилээж, бусдаас зөвлөгөө авч, чадах чинээгээрээ л шийдэх гэж бодож явсан байлгүй.

### Хамгийн хурдтай ажиллаж байгаа сайд

Салбар болгонд л асуудал байгаа. Ерөөсөө Монгол Улсад шийдэх асуудлаас их юм алга. Тэр дундаа Улаанбаатар хотод. Тэгвэл шинээр байгуулагдсан Засгийн газраас хамгийн хурдацтай, мэдрэмжтэй ажиллаж байгаа нь Г.Мөнхбаяр болов уу. Хийж, хэрэгжүүлж байгаа ажлыг нь харахад шүү дээ. Мэдээж бусад сайдууд дунд ч гайгүй ажиллах гэж хичээж байгаа хүмүүс бий, бий. Харин Г.Мөнхбаяр сайд салбараа илүү сайн мэддэг хүний хувьд хаанаас нь эхэлж ажиллахаа мэдрээд байх шиг байна. Ажлаа аваад удаагүй байхдаа л Барилгачдын холбооны удирдлагуудтай шууд уулзалт хийж, санаа оноогоо хуваалцаж, асуудлаа ярилцсан. Улмаар хамтар ажиллахаар болсон. Барилгачдын холбооноос 14 төрлийн санал тавьсан. Ингээд л хамгийн ойр ажиллах, хамтрах ёстой барилгачидтайгаа ойлголцох эхлэлээ тавьчихаж байгаа юм. Түүний дараахан БНХАУ-аас манай улсад суугаа Элчин сайд Шин Хаймингтай уулзаж, хамтын ажиллагаа эхлүүлсэн. Уулзалтын үеэр БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй Улаанбаатар хотын 7, 14 дүгээр хорооллын орон сууц, Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхийг чухалчилсан. Мөн тэрбээр АХБ-ны төлөөлөлтэй уулзаж, гэр хорооллыг орон сууцжуулах асуудал дэд бүтэц, газар доорх байгууламж, цэвэр бохир усны болон дулааны шугам сүлжээний асуудал дээр л ирээд гацах нь тодорхой харагддагийг нийслэлийг удирдаж байсны хувьд мэдэж буйгаа илэрхийлж, цэвэрлэх байгууламжийн талаар ямар ажил хийх төлөвлөгөөтэй байгааг асуусан. Тэр тусмаа цэвэрлэх байгууламжийг шинээр барих, өргөтгөх, бага оврын байгууламж барих уу гэдэг асуултад шууд хариулт нэхсэн юм. Энэ бол хандивлагч байгууллагын төлөөлөлтэй удирдаж байгаагийн хувьд асуудлыг шийдвэрлэж сурсан хүний тактик байсан бөгөөд АХБ-ны төлөөлөл удтал зөвлөлдсөний эцэст "Бусад орны туршлагаас харахад бага оврын байгууламж бариад тэр нь Төв цэвэрлэх байгууламждаа холбогддог байх нь бага хөрөнгөөр их ажил хийж болдог шийдэл учраас энэ хувилбарыг сонгох нь боломжтой" гэсэн хариу өгсөн. Гэх мэтээр түүний үр дүнтэй уулзалт, ажлуудыг дурьдвал их. Мэдээж шинэ сайдууд энд тэнд хүн хартай уулзаж, салбараа таньж мэдэх гэж хэрэндээ л хичээж байгаа л даа. Гэхдээ салбараа аль эрт мэдчихсэн, туршлага суучихсан хүн бусадтай яаж ярьж, асуудлыг ямар байдлаар шийдэж болдог вэ гэдгийг энэ мэт жишээгээр л харуулсан.

## ЧУХАЛ СЭДЭВ

# Ч.ГАНТУЛГА: ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ГЭР ХОРООЛЛЫН СУУЦЖУУЛАХ ГЭЖ ГАРГАСАН, ГЭВЧ ЗОРИЛГОДОО ХҮ

Н.ПУНЦАГБОЛД

*Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газар, Азийн Хөгжлийн банкны "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-тэй хамтран өчигдөр "Гэр хорооллыг шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөхөд төрийн болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоо" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Энэ үеэр НИХТ, Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны дэд хорооны дарга, БХБ-ын сайдын зөвлөх Ч.Гантулгыг "Чухал сэдэв" буландаа урьж, ярилцлаа.*

**-Гэр хорооллын дахин төлөвлөлт гэдэг Улаанбаатар хотод хамгийн түрүүнд шийдвэрлэх асуудал болчихоод байна. Өнөөдөр төр, хувийн хэвшлийнхэн, гадны хөрөнгө оруулагчид нийлээд, тал талаасаа л энэ асуудлыг ярилцаж байна. Ер нь ямар шийдэлд хүрч байх шиг байна?**

-Бид олон жил энэ асуудлыг бөөгнөрүүлж ирсэн. Шийдэх гэж янз бүрийн төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж ирсэн. Би энэ хэлэлцүүлэгт тавьсан илтгэлийнхээ үеэр дурьдсан. 2010 онд 70 орчим мянган айл өрхтэй байсан гэр хороолол 2016 оны байдлаар 220 мянгад хүрч, гурав дахин нэмэгдсэн байна. Нөгөө талаас барилга, орон сууц барьж байгаа тоо нь бас нэмэгдсэн. Одоогийн байдлаар зах зээл дээр бэлэн 80 мянган орон сууц байна. Түүний 30 орчим мянга нь ашиглалтад орчихсон, улсын комисс хүлээгээд авчихсан байгаа. Гэтэл айл өрх нь орж чаддаггүй. Ийм л байдал үүсчихсэн байна. Нэг талаасаа орон сууц нь баригдаад байгаа боловч нөгөө талдаа гэр хороолол нь жил болгон тэлж байдаг. Ийм л зүй тогтолтой болчихлоо. Яагаад ийм байдалд хүрчихэв. Үнэ тогтворжуулах хөтөлбөр гээд бид өчнөөн мөнгө зарцуулсан. Барилгын салбарыг дэмжие гээд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд ч багагүй мөнгө зарцуулсан шүү дээ. Тэр мөнгийг бондоос гаргасан. Үндсэндээ зээл л гэсэн үг. Тийм байтал үр дүн нь гараагүй. Тэгэхээр энэ бол бодлогын л алдаа байсан. Бид анхнаасаа журамтай, дүрэмтэйгээр энэ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ёстой байсан юм. Журам, дүрэм юун дээр илэрч гарах байсан бэ гэвэл, нийслэлийн орон сууцтай иргэд дахин байр худалдаж авах эрхтэй байх ёсгүй. Бид уг нь дахин төлөвлөлтийн хөтөлбөр гэдгийг гэр хорооллыг орон сууцжуулах л гэж гаргасан шүү дээ. Бохирдоод байгаа агаар, хөрсний асуудлыг шийдье гэж орон сууц барьж ирсэн биз дээ. Гэтэл яг зорилтот бүлэгтээ хүрч ажиллаж чадсангүй. Дахин төлөвлөлтөд зориулж гаргасан мөнгө хаана байна, хэдэн банк, барилгын компаниуд дээр л эргэлдэж байгаа. Бизнес хийж байгаа, боломжийн орлоготой хүмүүс нь 2-3, цаашлаад дөрвөн байр худалдаад авчихлаа. Нөгөө гэр хорооллын Дорж, Дулмаа авах ёстой байсан байрыг тэр нөхдүүд авчихаад, үнийн өсөлтийг бий болголоо. Улмаар авсан байраа эргүүлээд өнөөх Дорж, Дулмаад түрээслэх байдал ажиглагдаж ирж байна. Тэгэхээр бид энэ хөтөлбөрийг эхнээсээ л нэлээд хатуу нөхцөлтэйгээр хэрэгжүүлж эхлэх нь зөв байсан юм болов уу гэж би дотроо харж байгаа.

**-Нэлээд олон жилийн өмнөөс л орон сууцжуулах хөтөлбөр явж эхэлсэн. Сүүлийн жилүүдэд эрчимжиж байгаа байх. Энэ хугацаанд гэр хорооллоос ховхроод, орон сууцанд орсон хэдэн өрх байдаг юм бол. Энэ талаар гаргасан тоо баримт бий юу?**

-Өнгөрсөн дөрвөн жилд дахин төлөвлөлтийн 14 байршилд орон сууц барьж, 20 гаруй мянган айл өрхийг оруулна гэж байсан. Гэвч ердөө л 2000 гаруй айл л гэр хорооллоос гарч, орон сууцанд орсон гэсэн дүн бий. Энэ бол маш хангалтгүй үр дүн. Дахин төлөвлөлтөөр газрыг нь олголоо, төрийн мөнгөөр дэд бүтцийг холболоо. Харамсалтай нь барилгын компаниуд маань ийм л чадалтай болчихож. Өөрийн мөнгөөр 500, 1000 айлын орон сууц бариад, айлуудаа оруулаад, дээрээс нь барилгын компани нь өөрөө ашигтай ажиллаад, зээлээ, хүүгээ төлөөд явах боломж бараг байхгүй. Энэ бол бид гэр хорооллыг дахин төлөвлөх ажлыг анхнаас нь буруу явуулж ирсний л үр дүн гарч байгаа хэрэг. Тийм болохоор одоо суугаад, дүгнээд, ярилцаад, алдаа нь хаана байв, цаашид ямар дүрмийн дагуу "тоглох" вэ гэдгээ шийдэх ёстой. Ямар хууль эрхзүйн орчныг гаргаж ирэх вэ, нийслэл хотын статус ямар төвшинд байх ёстой юм, мөнгөө яаж босгож төсөл хөтөлбөрүүдээ дэмжиж явах юм гэдэг дээр л сайн бодож, ярилцаж шийдэх хэрэгтэй гэж л бодогдож байна.

**-Дахин төлөвлөлтийн ажил түр зогсчихоод байгаа. Тэгвэл хэзээнээс дахин төлөвлөлтийн ажил эхлэх юм бол. Одоогоор хүмүүсийн хамгийн их хүлээж байгаа хөтөлбөрүүдийн нэг нь л энэ шүү дээ?**

-БХБ-ын сайд Г.Мөнхбаяр Баянхошуу зэрэг хэдэн төвийн дэд бүтцийг шийдсэн гэж ярьсан. Энэ төвүүдэд бид дахин төлөвлөлтийг хийгээд, байшин барилгыг нь бариад, дэд бүтэцтэй нь холбоод явах нь зөв гэж байна. Энэ бол бас нэг л шийдэл. Нөгөө талаас нь харвал, гэр хороолол хаана, ямар газар голдуу байршиж байгаа билээ. Хотын баруун, зүүн хойд хэсэгт, дандаа уулын ам, гуу жалгатай хэсэгт л олон айл амьдарч байна. Тэгвэл ийм газарт бид өндөр байшин барих нь зөв үү. Халуун, дулаанаар нь хангахад хүртэл ачаалал маш их шаардана. Нэгдүгээрт, үүнийг бодож үзэх хэрэгтэй. Хэрвээ буруу юм бол тэнд бид юу хийж, ямар барилга барих ёстой юм. Дэлхий дээр үүсээд, 20, 30 жил хэрэглэчихсэн технологиудаас алийг нь ашиглах хэрэгтэй юм бэ. Энэ бүхнийг бодолцож, тооцож үзээд бид технологи оруулж ирэх нь зөв, гэхдээ Монголд таарсан, зардал бага, жилийн дөрвөн улиралд барьж, ашиглалтад оруулах боломжтой. Мөн жилийн 360 гаруй хоногийн 280 орчимд нь манайд нартай байдаг. Тийм болохоор нарны хавтангуудыг бүрэн ашигласан, тэр шийдлүүд нь орсон, төрийн үйлчилгээ, интернэтийн бүхий л боломжуудыг хангасан макро сити хотхонуудыг байгуулаад явбал зардал багатайгаар иргэдийн тухайн байршилд аз жаргалтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх юм байна гэж тооцсон. Энэ тал дээр судалгаа хийсэн. Одоо судалгааны тайлан, дүгнэлтүүд гарчихсан. Цаашлаад нийслэл болон БХБЯ, Засгийн газар дээр асуудлыг хэлэлцэж, тал талаасаа саналаа нэмэрлэж, илүү сайжруулаад, хэрэгжүүлээд явах боломж байгаа. Монголчууд өөрсдөө суух амины орон сууцаа бариад амьдарчих чадвартай хүмүүс. Ганцхан боломжийг нь л олгож, нээж өгөх хэрэгтэй. Бодлогоор нээж өгөх ёстой гэж л бодож байна.

**-Улаанбаатар хотод дэд төвүүд үнэхээр хэрэгтэй байгаа. Иргэн тухайн амьдарч байгаа байршлаасаа гарахгүйгээр төрийн болоод бусад үйлчилгээгээ авчихдаг байвал ядаж л түгжрэлийн асуудал ч гэсэн шийдэгдэнэ шүү дээ?**

-Яг тийм. Өнөөдөр бид дэндүүд төв рүүгээ хандсан үйлчилгээг бий болгочихсон. Төвд нь л хамаг үйлчилгээ, яам, тамгийн газар нь байдаг. Үүнийг бид задалж өгөх хэрэгтэй. Манай намын мөрийн хөтөлбөрт дагуул хотын талаар бодлогын чиг баримжаатай 2-3 төлөвлөгөөг тусгаж өгсөн байгаа. Эмээлт, Багануур, Налайхын аж үйлдвэрийн парк. Хөшигийн хөндийн нисэх буудлыг дагасан хот. Хүй долоон хутагт Монгол наадам цогцолбор гээд хэд хэдэн газарт 10-15 хүн амьдрах боломжтой хотуудыг бид бий болгоно. Яахав, энэ ажлыг хийхэд цаг хугацаа болоод санхүүгийн асуудал тулгарна. Тэр гарц шийдлүүдийг бид олох л хэрэгтэй. Бид хотын нягтаршлыг дэндүү их бий болгочихсон. Үүнийг төрийн үйлчилгээгээр нь задалж өгөх боломж байна. Өнөөдөр Долоон буудал, Чингэлтэйд амьдарч байгаа иргэд Дүнжингарав, Драгон, Мишээл төв дээр очиж төрийн нэг цэгийн үйлчилгээгээ авч байгаа. Энэ чинь өнөөх ухаалаг шийдэл чинь мөн юм уу. Гэх мэтээр бодож үзэх ёстой асуудлууд маш их байна. Тэгвэл хотын хөгжлийг яагаад хорооноос эхэлж болохгүй гэж. Хороон дээр 2-3 хүн суугаад, хүн амын ажил бүртгэл хийдэг биш. Тэр хүмүүсээ чадваржуулаад, интернэтийн орчинд программ хэрэглэдэг болгох хэрэгтэй. Улмаар интернэтийн орчинг нь сайн хангаж өгөөд, төрийн үйлчилгээгээ хороонд нь үзүүлдэг болгоё л доо. Энэ мэтчилэн хэд хэдэн зүйлийг технологийн шийдлээр шийдэх боломж байгааг судалж үзсэн. Түүнийгээ ч өнөөдрийн хэлэлцүүлэгт тавьсан танилцуулгынхаа үеэр дурьдсан. Хаягжилтын асуудлыг өнөөдөр энгийнээр шийдэж болж байна. Монгол Улсын айл өрх болгон хаягаа ухаалаг утсан дээр гурван үгээр авах боломжийг бид нээж өгөх гэж байгаа. Английн компанитай хамтраад энэ ажлыг хийнэ. Зардал мөнгө бараг л гаргахгүйгээр шийднэ. Өнөөдөр бид хаягжилтаа бүрэн шийдэж чадаагүй л байгаа шүү дээ. Гэр хорооллын айлуудын хаяг эмх цэгцтэй биш. Тэгвэл гэртээ сууж байгаад, ухаалаг утсаа асаагаад, хэрэгтэй апплейкешнаа татаж суулгаад, түүн дээрээ өөрийнхөө хашаа, байшингийн хаягыг гурван үгээр л тодорхойлоод өгчихнө. Тэр гурван үг танай хаяг. Танайд онцгой байдал, эрүүл мэндийн үйлчилгээ, цагдаа, шуудан өнөөх гурван үгээр чинь google map-аар хайж очоод л үйлчилгээгээ үзүүлчих боломжтой болно.

**-Ямар ч хамаагүй гурван үг хийж болох юм уу. Давхцах тохиолдол гарвал яах вэ?**

-Ямар ч хамаагүй гурван үг байж болно. Давхцах тохиолдол гарахгүй. 100 саяд нэг удаа л давхцах магадлалтай гэж үздэг. Манайх шиг цөөн хүн амтай улсад бол бүр ч давхцахгүй. Тийм болохоор ийм боломжуудыг ашиглаж, ухаалаг хот болох боломж байна. Нүдээ жаахан нээгээд, соргог байж чадвал дэлхий нийтэд ашиглаж эхэлж буй хөгжлийн чиг хандлагыг оруулж ирээд, дагаж явах бүрэн боломжтой байна. Байшингийн технологи дээр ч гэсэн өндөр өртөгтэй, бетон, арматуртай барилга гэр хороололд хэрэг байгаа юм уу. 2-3 давхар, 1-2 өрөөтэй нийтийн, дотроо хүн амьдрах бүх нөхцөл бололцоог хангасан орон сууцнуудыг хямд өртгөөр барих боломж нь байна шүү дээ. Яагаад түүнийг сонгож авахгүй, заавал өндөр өртөгтэй барилга барих гээд яваад байгаа юм. Энэ чинь л өөрөө бодлогын алдаа байсан байхгүй юу.

**-Барилгын компаниудыг дэмжих чиглэлийн бодлогоо л илүү түлхүү бариад байсан юм биш үү?**

-Үнэ тогтворжуулж байна л гэсэн. Хэдэн худалдааны компаниудыг л дэмжлээ шүү дээ. Тэглээ гээд орон сууцны үнэ буураагүй. Өнөөдөр орон сууцны үнэ ам.метр нь дунджаар 1.7 саятай байна. Хэрвээ үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилт нь зөв байсан бол өнөөдөр орон сууцны үнэ 1.25 саяаас хэтрэхгүй л байж байх ёстой. Гэтэл үнэ өсчихсөн байна. Энэ бол алдаатай бодлогын үр нөлөө л гэж харж байгаа. Бид хуучнаасаа салах дургүй хүмүүс юм. 60, 70, 80 онд Орос ах нар бидэнд барилга барихыг зааж өгсөн. Орос школ л яваад байна. Бетон, арматур л хэрэглэж байгаа. Барилгын коллеж, ТМС-иудад миний сонссоноор 70, 80 оны барилгын инженер техникийн сурах бичгээр л хичээл заадаг гэж байгаа. Гэтэл өнөөдөр цаг үе арай өөр болчихлоо. Тухайн улсын онцлог, газар зүйн байршил, уламжлалыг дагаж бид өөрсдөө хөгжлөө тодорхойлохгүй бол хэт хэвшмэл байдлаасаа салж чадахгүй л яваад байна. Бүх зүйл нээлттэй байна шүү дээ. Хамгийн гол нь санаачилгатай, зоригтой хөдлөө, бие биеэ дэмжээд, хамтдаа суугаад, зөв бодлого, дүрэм журмыг гаргаж ирэх ёстой л гэж бодож байгаа.

> ...Зөөврийн цэвэрлэх байгууламж авчраад л 5000 айлын дунд тавьчихаж байна. Тэгээд бүх бохироо холбочихож байгаа юм. Улмаар бохироо цэвэрлээд, саарал усаа гаргаад авчихаж байгаа юм. Харин саарал усаараа тухайн хотхоныхоо зүлэг ногоог усалж болж байна. Тэнд үйл ажиллагаа явуулж байгаа авто угаалгын төвдөө ашиглаад, машинаа угаачихаж болж байгаа юм. Энэ чинь л нөгөө яриад байгаа ногоон, эко хөгжил чинь юм шүү дээ...




АЛ СЭДЭВ

# ИРГЭДЭЭ ОРОН
# РЧ ЧАДСАНГҮЙ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**-Гэр хорооллыг дахин төлөвлөх янз бүрийн арга байгаа талаар ярьдаг. Ямар ч байшин барилга барьж болно. Хамгийн гол нь халаалт, дулааны асуудлыг яаж шийдэх юм бэ. Манай Цахилгаан станцуудын хүчин чадал хүрэх үү гээд олон асуудал байна шүү дээ?**

-Мэдээж дэд бүтцийг шийднэ гэдэг том асуудал. Гэхдээ л бид шийдэх ёстой. Амгалангийн Дулааны станцыг ашиглалтад оруулчихсан. Энэ станцид нөөц бололцоо байгаа. Хотын зүүн хэсгийн гэр хорооллуудыг нэгдсэн дулаанаар хангах боломж нь бий. Дулаанаар хангаад, гүний усаар усныхаа асуудлыг шийдээд явлаа гэхэд бохир гарна. Гэтэл манай төв цэвэрлэх байгууламж ачааллаа даахаа болиод, одоо шинэчлэх асуудлыг ярьж эхэллээ. Шинэчилж болно оо. Гэхдээ дараагийн 50 жилд ямар нэг асуудалгүй технологийг ашиглах ёстой. Гэр хорооллын хувьд бид нөгөө бичил хот гэдгээр нь цэвэрлэх байгууламжуудыг тусад нь шийдэж өгөх хэрэгтэй. 5, 10, 15 мянган айлын дунд нэг цэвэрлэх байгууламжийг газар дээр нь шийдэж өгөх боломжтой. Би дахиад л технологи ярих гээд байна л даа. Өнөөдөр Унгар, Герман, Австри, Чех улсууд цэвэрлэх байгууламж тал дээр ноу хау гаргаад, дэлхийн эрдэмтдийн зөвлөлөөс Гран при шагнал аваад явж байна. Тэд био аргаар бохирыг цэвэрлэдэг болчихсон. Зөөврийн цэвэрлэх байгууламж авчраад л 5000 айлын дунд тавьчихаж байна. Тэгээд бүх бохироо холбочихож байгаа юм. Улмаар бохироо цэвэрлээд, саарал усаа гаргаад авчихаж байгаа юм. Харин саарал усаараа тухайн хотхоныхоо зүлэг ногоог усалж болж байна. Тэнд үйл ажиллагаа явуулж байгаа авто угаалгын төвдөө ашиглаад, машинаа угаачихаж болж байгаа юм. Энэ чинь л нөгөө яриад байгаа ногоон, эко хөгжил чинь юм шүү дээ. Энэ мэт бэлэн технологи байгаад байхад бид хийж, хэрэгжүүлэхгүй, бүгд бохироо төв цэвэрлэх байгууламж руу аваачиж холбох гээд байгаа юм бэ. Өөрөөр сэтгээд явах боломж байгаад байхад нэг хайрцагт өөрсдийгөө бариад байх шаардлага алга. Тийм болохоор энэ хайрцгийг эвдэж, хэвшмэл аргуудаас татгалзах хэрэгтэй. Чөлөөтэй сэтгэе л дээ, бидэнд боломж байна. Тиймдээ ч бид судалгаа хийгээд, танилцуулаад, тайлангуудаа гаргачихсан байгаа. Ганцхан ажиллах л үлдсэн.

**-Үе үеийн эрх баригчид, хотын удирдлагууд сайхан сайхан технологийг судлаад, яриад л байдаг. Одоог болтол хийгээд, хэрэгжүүлчихсэн юм бага л байна. Таны ярьж байгаа технологиуд ч тун сайхан сонсогдож байна. Гагцхүү ойрын хугацаанд ажил хэрэг болгох уу. Хийж хэрэгжүүлэх боломж байна уу?**

-Эхлүүлнэ. Бид хий хоосон юм яриад байгаа юм биш. Бид судалгаа хийхээсээ өмнө Хотын болоод хурлын даргатай ярьж, зөвлөсөн. Бид иим зүйл хийнэ гэдгээ хэлсэн, дэмжсэн. Мэдээж олуулаа суугаад хэлэлцвэл илүү үр дүнтэй байдаг. Тийм болохоор Гэр хорооллын хөгжлийн хороо болоод Нийслэлийн холбогдох агентлаг, газруудтай бүгдтэй хамтарч ажиллана. Энэ бол хий хоосон яриа биш, хэрэгжих ажил. Бид хэдэн хотхон байгуулж чадах вэ. Нэг хотхон 500, 1000 хүнтэй байна гэж тооцвол хэдийг байгуулж чадах бол гэдгийг хэлж мэдэхгүй байна. Харин ойрын 2-3 жилийн дотор гурван хотхон байгуулах зорилготой байгаа. Мэдээж гадаад түншлэгчид маань энэ ажилд идэхтэй оролцох ёстой. Бид хоорондоо ойлголцох хэрэгтэй. Одоо бид за гэж хэлэх цаг ирсэн. Засгийн газар, барилгын компаниуд, банк, банкны холбоо, гэр хорооллын оршин суугчид, нийслэл за гэж хэлэх ёстой юм байна. Энэ олон "За"-г нэгтгэж чадсанаар гэр хорооллыг дахин төлөвлөх, бичил хотыг байгуулах ажлыг хэрэгжүүлж чадна.

**-Одоогоор улс орны эдийн засаг тийм ч сайхан биш байгаа. Ойрын хэдэн жилдээ ч сэвхийгээд сайхан болчихгүй гээд л байна. Мэдээж гэр хорооллыг дахин төлөвлөөд, ямар ч ажил хийсэн хөрөнгө мөнгө шаардагдаж таарна. Тийм болохоор хөрөнгө оруулалтын асуудлыг яаж шийдэх гэж байна. Ямар гарц байна?**

-Нийслэл хот санхүүгийн тодорхой статустай байх ёстой. Эрхтэй гэсэн үг. Өөрөө бондоо гаргачихдаг, үнэт цаасны арилжаанд орчихдог. Тэндээсээ хөрөнгөө босгодог, ашгаа гаргачихдаг, тэр ашгаараа хөгжлийн хөтөлбөр төслүүдээ санхүүжүүлчихдэг. Иим л байх хэрэгтэй байна. Нийслэл хотын эрхзүйн орчны шинэчлэлийн хүрээнд энэ асуудлууд яригдаж байгаа. Харин бидний байгуулах гээд байгаа бичил хотхоны хувь эхний хэдийг нь гадны хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөж байна. Мэдээж арилжааны банкуудыг оролцоно. Ипотекийн зээл маягаар оролцож болно. Мэдээж Монголын барилгын компаниуд энэ ажлыг хийх учраас тэдэнд зээл өгч, санхүүжүүлж оролцож болж байна. Ерөнхийдөө гол хөрөнгө оруулалтаа гаднаас босгоод, ажлыг хийж болдог юм шүү гэдгийг л харуулахаар зорьж явна.

**-Гурван хотхон байгуулах зорилготой гэлээ. Яг хаана байгуулах вэ, төлөвлөсөн үү?**

-Энэ асуудлыг хотын удирдлагуудтай ярилцаж, ерөнхий төлөвлөгөөний дагуу л хийх ёстой. Анх хийж байгаа шинэ зүйл маш олон эрсдлийг дагуулж байдаг. Эрсдэлийг багасгах үүднээс бид хотын төвтэйгээр ойрхон л хотхоноо байгуулна гэж ярилцаж байгаа. Магадгүй Гандан, эсвэл Ногоон нуур орчимд ч юм уу. Ингэж ажлаа эхлүүлэх нь зөв юм уу гэж харж байгаа. Тэгэхгүй аваачаад Дарь-Эхэд, уулын аманд, гэр хорооллын дунд 250 айлын хотхон байгуулчихлаа гэж саная. Оршин суугчид маань сэтгэл ханамжгүй байна биз дээ. Утаан дунд хотхон барьчихаар. Эхнээсээ л энэ мэтээр бодлогын алдаа гаргаад эхэлбэл цаашид ажил сайхан үргэлжлэхгүй шүү дээ. Тийм болохоор хаана байрлах тал дээр тун болгоомжтой хандана.

**-Татүрүүнд ногоон хөгжлийн талаар цухас дурьдсан. Шинээр барихаар төлөвлөж байгаа хотхонууддаа нарны эрчим хүчийг ашиглана гэсэн үү. Тэр талаар жаахан дэлгэрүүлээч?**

-Өнөөдөр дэлхийн чиг хандлага ногоон ирээдүй рүү чиглэж байна. Олон улсын жишээнүүдийг дурьдаж болж байна. Арабын нэгдсэн улс гэхэд нар, салхиараа эрчим хүчээ хангана. Цаашлаад 2030-2035 он гэхэд Европын эрчим хүчний 30 хувийг хангана гэдэг том зорилт тавиад явж байгаа. Ойрын хөршөө л аваад үзэхэд, Хятадын нийслэл Бээжин хот агаарын бохирдлоосоо болоод нүүрс түлж дулаан, эрчим хүч гаргадаг үйлдвэрүүдээ татаж эхэллээ. Гэх мэт жишээ байна. Бид ч гэсэн энэ чиг хандлага руу одоо л орох хэрэгтэй. Дахин төлөвлөлтөөр хийх амины болон нийтийн орон сууц дээрээ нарны хавтангуудыг бүрэн ашиглана гэж төлөвлөж байна. Би түрүүнд цухас дурьдсан даа. Одоогоор бол төсөөллийн зургаа гаргачихсан. АНУ-ын Тесла компанийнхантай хамтарч ажиллаад, нарны хавтангуудыг нь Монголд оруулж ирж, гэр хороололд хийгдэх ухаалаг, бичил хотхоны байшингуудын дээвэрт суурилуулъя гэж бодож байгаа. Хэрвээ тэгж чадвал хэрэглээний цахилгаанаа бүрэн хангах боломжтой. Шийдлүүдээ гаргаад, зураг тооцооллоо боловсруулаад хийж болно. Бид тэр компанийнхантай холбогдсон. Ерөөсөө эхнээс нь л цогцоор нь шийдээд явъя гэж бодож байгаа.


## "АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨҮГ-ЫН "АВТОТЭЭВРИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН" ЦОЛ ТЭМДГИЙН ЗАГВАР ЗОХИОХ ШАГНАЛТ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2016.11.22 Улаанбаатар хот

1. **Зорилго:**
Засгийн газрын 1997 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн төрөл болон тэдгээрийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-д Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн тогтоолоор 48 дахь заалт "Автотээврийн тэргүүний ажилтан" цол тэмдэг нэмсэнтэй холбогдуулан цол тэмдгийн загвар гаргах уралдаан зарлах.

2. **Хамрах хүрээ:**
Цол тэмдгийн эх бэлтгэж, загвар гаргаж, үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд оролцох боломжтой.

3. **Ерөнхий шаардлага:**
- Загвар нь автотээврийн салбарын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг бэлэгдсэн дүрслэлтэй.
- Хэмжээ: Урт 50мм, өргөн 30мм, зузаан 2,5мм харьцаатай.
- АТҮТ ТӨҮГ-ын логоны үндсэн өнгийг /шар, цэнхэр/ багтаасан байх.
- Цол тэмдгийн загварыг, зургийн хамт ирүүлэх. /А4 –ийн цаасан дээр тусгах/
- Загварын өгүүлэмжийн тайлбар, өнгөний код, орц хийцийн санал, шаардагдах зардлын тооцоог гаргасан байна.
- Бэлгэдлийг зураг, графикаар дүрслэхээс гадна бичвэр оролцуулж болно.
- Загвар дизайны өвөрмөц шийдэлтэй, дахин давтагдашгүй хийцтэй байх.

4. **Шагнал урамшуулал:** 1,0 сая төгрөг /Нэг сая төгрөг/

5. **Мэдээллийг олон нийтэд хүргэх хэлбэр:**
- Өдөр тутмын сонин хэвлэл
- Сошиал медиа хэлбэрээр

6. **Уралдаанд оролцох материалыг хүлээн авах хугацаа:**
Уралдаанд ирүүлэх бүтээлийг 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 17:00 цаг хүртэл хүлээн авна.

7. **Материал хүлээн авах хаяг:**
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын төв байр, Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтэс, ХМОНХМэргэжилтэн Ц.Мягмарсүрэн, Холбогдох утасны дугаар 86063600

8. **Уралдааныг дүгнэх:**
Уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг томилогдсон ажлын хэсэг тавигдсан шаардлагын дагуу дүгнэж 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж сонгон шалгаруулна.



## "БАТЛАН ХАМГААЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН НЭГДЭЛ" ТӨҮГ АВТОБУС НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛНА

ОХУ-д үйлдвэрлэсэн ПАЗ маркийн дизель хөдөлгүүртэй, 2 хаалгатай, хүн зөөврийн зориулалттай /30-аас доошгүй суудалтай/ Монголын нөхцөлд тохиромжтой автобус 2 нэгж, ширхэгийг яаралтай худалдаж авна.

**Материал хүлээн авах хугацаа:**
2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл.

**Хаяг:**
Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, Дандарбаатарын гудамж-51, Засгийн газрын 7 дугаар байрны дэргэд, БХАҮН ТӨҮГ-ын байр.

**Холбоо барих утас:**
70164555, 99181100, 99519196




# Р.Эрдоганы ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ ҮРГЭЛЖИЛСЭЭР...

Б.ДАВААХҮҮ

Хэмжээлшгүй эрх дархтай Туркийн Ерөнхийлөгч Ресеп Тайип Эрдоганыг суудлаас нь унагах зорилготой цэргийн эргэлт хагас өдөр ч бололгүй замхарснаас хойш тус улсын эрх баригчид "Их цэвэрлэгээ"-гээ үргэлжлүүлсээр байна. Хамгийн сүүлд авсан мэдээллээр гэхэд 15 мянган төрийн албан хаагч ажлаасаа халагдаж, 375 төрийн бус байгууллага хаалгаа барьжээ. Хэргийг эргэн сануулбал, өнгөрөгч долдугаар сард танк, нисдэг тэргээр зэвсэглэсэн армийн бүлэглэл Туркийн гол хотуудын чухал цэгүүдийг эзлэн авахыг оролдсон бөгөөд энэ үеэр нийт 265 хүн амь үрэгдсэний 161 нь энгийн иргэд, 104 нь босогчдын талынхан байсан гэдэг. Харин Газар дундын тэнгисийн эрэгт амарч байсан Ерөнхийлөгч Эрдоган Истанбулд эргэн ирж, иргэдийг гудамжинд гарч тэмцэхийг уриалснаар эргэлт хийх гэсэн оролдлого бүтэлгүйтсэн. Цэргийн эргэлт тус улсад 30 орчим жилийн дараа гарсан нь энэ байсан юм. Тэгвэл үүний дараа Р.Эрдоган цэргийн эргэлт хийх оролдлогыг бурхны бэлэг хэмээж, "их цэвэрлэгээ" хийхээ тунхаглаж байв. Энэ хүрээнд улс даяар онц байдал тогтоож, бослого өдүүлсэн цэргийн албан тушаалтнууд хийгээд шүүгч, прокурор, бүр боловсролын байгууллага руу хүртэл орж төрийн албан хаагчдыг хоморголон халж байлаа.

> ...Цэргийн эргэлт тус улсад 30 орчим жилийн дараа гарсан нь энэ байсан юм. Тэгвэл үүний дараа Р.Эрдоган цэргийн эргэлт хийх оролдлогыг бурхны бэлэг хэмээж, "их цэвэрлэгээ" хийхээ тунхаглаж байв...

Туркийн эрх баригчид энэхүү цэргийн эргэлт хийх оролдлогыг шашны номлогч Фетуллах Гулен хөшигний араас удирдсан гэж үзэж, түүнтэй холбоотой бүхий л боловсролын байгууллага, төрийн албан хаагчдыг шалгаж, тагнан, хорьж цагдаж эхэлсэн байдаг. Хэдийгээр онц байдал зарлаад нэлээд хугацааг үдсэн ч, "их цэвэрлэгээ" тойрсон баривчилгаа дуусаагүй байгаа бололтой. Цэвэрлэгээ эхэлснээс хойш нийтдээ 100 гаруй мянган албан хаагч ажилгүй болж, хэдэн арван хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаагаа зогсоосон байна. Тэгвэл энэ удаагийн баривчилгаагаар цагдаа, цэргийн алба хаагчид, Дотоод хэргийн яамнаас эхлээд газар агентлагт ажилладаг нийтдээ 15726 хүн ажлаасаа халагдах арга хэмжээ авхуулжээ. Мөн хүний эрх, соёл, эмэгтэйчүүдтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг 375 Төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа зогсоосон байна. Цаашдаа ч цэвэрлэгээ үргэлжилсээр байх төлөв ажиглагдаж байгаа юм. Учир нь хоморголон халах үйл ажиллагааг онц байдлын хүрээнд хэрэгжүүлж буй бөгөөд цэргийн эргэлтээс хойш өнгөрөгч аравдугаар сард дахин гурван сараас сунгаж, ирэх оны нэгдүгээр сар хүртэл үргэлжлүүлэхээ мэдэгдсэн. Тиймээс энэ хугацаанд эрүү шүүлт, цаазаар авах ялыг хориглон иргэдийн амьд явах, шударга шүүлгэх эрхийг баталгаажуулдаг Европын хүний эрхийн конвенц үйлчлэхгүй.

Гэхдээ өрнөдийн зарим орнууд, хүний эрхийн байгууллагууд Туркийн эрх баригчдын энэ мэт үйл ажиллагааг шүүмжилж, цэргийн эргэлтэд оролцсон хүмүүс бус Ресеп Тайип Эрдоганы үйлдлийг зорилготойгоор шүүмжлэгчдийг хоморголон баривчилж байгааг онцолж байна.

## Зан үйлийн нэр барьж гэмт хэрэг үйлджээ

Хар тивийн зүүн өмнөд этгээдийн Малави улсад ХДХВ-ын халдвартай атлаа "Ариусгах зан үйл" хийх нэрийн дор 100 гаруй охид бүсгүйчүүдтэй бэлгийн харилцаанд орсон эрийг баривчлан шүүж, чанга дэглэмтэй хорих ангид хоёр жил ял эдлүүлэх шийтгэл ногдуулжээ. Эрик Анива гэгч 45 настай эрэгтэй уг хэргийг үйлдсэн байна. Тэрбээр орон нутгийн уламжлалт зан үйл хийх нэрийг барьж, 12 настай балчир охиноос эхлээд нийтдээ 104 охид, бүсгүйчүүдтэй бэлгийн харилцаанд орсон гэдгээ хүлээжээ. Орон нутагт хэрэглэгддэг "Ариусгах зан үйл" –ийг малавичууд эдүгээ бараг үйлдэхээ больсон гэнэ. Гэвч тус улсын өмнөд этгээдийн зарим бүс нутагт хамаатан садныхаа хэн нэгнийг үхэл зовлонгоос гэтэлгэхийн тулд муу ёрын сүнсийг хөөх "Цөөвөр чоно" гэж нэрлэгдсэн эртэй ганц бие эмэгтэйчүүд бэлгийн харилцаанд орж үүнийхээ төлөө урамшуулал өгдөг зан үйл одоо ч ашиглагддаг байна.

Түүнчлэн, "Цөөвөр чоно"-ын үүрэг гүйцэтгэж буй эрэгтэй насанд хүрээгүй охидын эцэг эх нь зөвшөөрсөн тохиолдолд биений юм ирэхээс нь урьтаж, охидыг эмэгтэй хүн болгох зорилгоор мөн "ариусгах зан үйл"-ийг үйлддэг гэнэ. Үүнийхээ төлөө эрэгтэйд мөнгө төлөх хэрэгтэй аж. Нутгийн иргэд энэхүү зан үйл охидыг айл гэрийн сайн эзэгтэй болгож, гэр бүлийг нь өвчин зовлон, ад зэтгэрээс хамгаалах хүчтэй байдаг гэдэгт итгэдэг юм байна. Энэ хачин ёс жаягийн талаар Английн Би Би Си агентлаг хамгийн анх мэдээлэл бэлтгэн дэлхий дахинаа хүргэсэн бөгөөд уг мэдээлэлтэй холбогдуулан Малави улсын Ерөнхийлөгч Артур Петер Мутарика зарлиг гаргаснаар Эрик Анива баривчлагдан шүүхэд дуудагджээ. Шүүх бүрэлдэхүүн түүнд хоёр жилийн ял ногдуулснаар энэ төрлийн гэмт хэргээр ял сонссон анхны хүн болсон байна.

## АНУ-ын шинэ Ерөнхийлөгчийн гэр бүл өдөрт нэг сая ам.доллар үрнэ

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль энэ сарын 8-ны өдөр явагдаж, үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп ялалт байгуулсан билээ. Тэрбээр ирэх оны нэгдүгээр сарын 20-нд албан ёсоор Цагаан ордон руу нүүх юм. Гэвч, шинэхэн тэргүүн хатагтай Мелания Трамп 10 настай хүүгийнхээ хамтаар Нью-Йоркийн Манхэттен дахь тансаг харшдаа үлдэнэ. Тэд энэ хичээлийн жилийг дуустал Цагаан ордон руу нүүхгүй гэрээ сахиж үлдэх юм. Гэхдээ Трамп Нью Йорк хотод байнга ирж, эхнэр хүү хоёртойгоо уулзаж байхаар төлөвлөсөн гэнэ. Тэгвэл шинэ Ерөнхийлөгч Трамп, түүний гэр бүлийнхэн, ач зээ нарын аюулгүй байдлыг батлан хамгаалахын тулд нэг өдөрт л нэг сая ам.доллар зарцуулагдах тооцоо гарчээ.

Энэ талаар Нью-Йорк хотын Терроризмтай тэмцэх газрын орлогч дарга Жон Миллер мэдээлжээ. Үл хөдлөх хөрөнгийн тэрбумтны гэр бүлийнхэн бүгд л Нью Йоркт амьдардаг бөгөөд тэдний аюулгүй байдлыг хамгаалахын тулд хотын цагдаагийн газрынхан нэлээд өргөн бүрэлдэхүүнтэй ажиллах шаардлагатай болж байгаа гэнэ. Доналд Трамп гурван удаа гэрлэсэн бөгөөд таван хүүхэдтэй билээ.

## Нас барсан хамаатнаасаа байшин өвлөсөн залуу асар их алт олжээ

Францын хойд этгээдийн Руан хотод нас барсан хамаатныхаа том байшинг нь өвлөж авсан залуу асар их хэмжээний алтан гулдмай олжээ. Тэрбээр алт эрдэнэсийг байшинд нуусан байхыг нь олж илрүүлсэн бөгөөд тэдгээр эрдэнэсийн нийт үнэлгээ нь 3.5 сая евротой тэнцэх аж. Орон нутгийн "Ла Депече" гэх сонинд залуу байшингийн өнцөг булан бүрээс нийтдээ 100 кг жин бүхий алтан зоос, сав нуусан байсан гэж ярьжээ. Байшинд 5000 ширхэг алтан зоос, 12 кг жинтэй алтан ваар сав хоёр, нэг кг-ын жижиг сав 37 ширхэг байсан байна. Эдгээр эрдэнэсийг тавилгын доор, ор дэрний цагаан даавууны доор, угаалгын өрөө гэх мэт хүний санаанд оромгүй газруудад нуусан байжээ. Одоогоор гэрийн эзэн хэн байсан эсэх нь тодорхойгүй байгаа бөгөөд түүнтэй холбоотой ямар нэг мэдээлэл байхгүй байна. Байшинг өвлөсөн залуу тавилгаа өөрчлөхөөр хөдөлгөх үедээ санаандгүй алтыг олжээ. Тэрбээр тавилганы дор тавьсан байсан цагаан тугалган хайрцгийг олж, нээж үзэхэд дотор нь алтан зооснууд гарч ирсэн байх аж. Түүний дараа нууц хайрцаг, вискины лонх гэх мэтээр эрдэнэс нуусан савнуудыг олж, хэмжээлшгүй их баялгийн эзэн болсон байна. Одоогоор залуу эрдэнэсийг дотоод, гадаадын зах зээлд худалдан борлуулах хүсэлтэй байгаа гэнэ.

## №5 Хүн амын насжилтын улмаас тэтгэврийн тогтолцоо "сүйрэх үү"

*Манай сонин долоо хоног бүрийн баасан гарагт нийгмийн даатгалын үйлчилгээ, түүний талаархи түгээмэл асуулт хариултын буланг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага / ЖАЙКА/-ын Монгол Улсад хэрэгжүүлж буй Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн мэргэжилтнүүдтэй хамтран бэлтгэн хүргэж байгаа билээ. Уншигчдын төдийлөн мэддэггүй ч, заавал мэдэж байх ёстой түгээмэл асуултад Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн ахлах зөвлөх Ямашита Мамору хариулж байна.*

**-Японы хүн амын насжилт нэмэгдсэний улмаас тэтгэврийн тогтолцоо нь "сүйрч байгаа" гэж ярих юм билээ. Энэ талаар тодруулахгүй юу?**

-"Тэтгэврийн тогтолцоо сүйрнэ" гэж яг юуг хэлэх вэ гэдгийг юун түрүүнд авч үзье. Сайтар эргэцүүлээд үзье л дээ. Тэтгэврийн тогтолцоо нь тухайн улсад амьдарч буй бүх хүмүүст хамаатай бөгөөд тэдгээр иргэдийг эрсдэлээс хамгаалах систем юм. Тэгвэл энэ тогтолцоо "сүйрнэ" гэж үзвэл нийгмийн даатгал төлөх хүнгүй болох, эсвэл даатгал төлөгч бүх хүн эрсдэлд орно гэсэн үг. Нийгмийн даатгал төлөх хүнгүй болно гэхээр тухайн улсад хүн амьдрахгүй болно гэсэн үг шүү дээ. Ийм тохиолдолд дан ганц тэтгэврийн тогтолцоо үгүй болох асуудал яригдахгүй. Дараагийнх нь нийгмийн даатгал төлөгчид бүгд эрсдэлд орно гэх хувилбарыг аваад үзье. Энэ утгаар жишээ татахад, тухайн оронд амьдарч буй бүх хүн өндөр настай болно гэсэн үг. Үүнийг ч бас төсөөлөхөд бэрх байгаа биз. Тэтгэврийн тогтолцоонд санхүүжилтыг хүн ам зүйн тодорхой үзүүлэлт болон эдийн засаг гэх мэт ирээдүйд үүсч болохуйц тодорхой бус нөхцөл байдалтай уялдуулан урт хугацаанд тогтвортой байхаар зохицуулсан байдаг.

Тиймээс ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдал, шинээр төрөх хүүхдийн тоог жаахан гутранги байдлаар төсөөлж үзвэл, зуун жилийн дараа л хүндрэл гарч болзошгүй төлөв ажиглагдаж байгаа. Гэхдээ ирээдүйн эдийн засгийн байдал, шинээр төрөх хүүхдийн тоог эдүгээ "өөрчлөх боломжтой". Өнөөгийн нийгэмд амьдарч буй эрин үеийнхэн ирээдүйгээ өөрчилж чадах учраас тэтгэврийн тогтолцооны найдвартай байдал цаашид ч улам сайжирсаар байх болно. Тэгэхээр 100 жилийн дараах явдалд санаа зовох бус, харин ч одоо амьдарч буй нийгмээ илүү сайн сайхан болгож, ирээдүйн талаархи гутранги үзлээ хаях нь чухал болов уу.




*Япон улсын тэтгэврийн тогтолцоо нь хуваарилалтын буюу залуу үеийнхэн төлсөн даатгалын шимтгэл тухайн үеийн хөгшчүүдийн тэтгэвэрт зориулагддаг системтэй бөгөөд өндөр насжсан өнөөгийн нийгэмд дан шимтгэлийн орлогоор тэтгэвэр олгоход хүндрэлтэй тул олон жил хуримтлуулсан тэтгэврийн хуримтлалаа авч зөв зохистой ашигладаг. Улмаар залуу үеийнхний үүрэх ачааг тодорхой хэмжээнд барихад чухал нөлөөтэй байдаг.*

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## ЗАЛУУСЫН 50 ОРЧИМ ХУВЬ НЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЭЛ ХААНААС АВАХАА МЭДДЭГГҮЙ

Н.БАТЗАЯА

*Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс их, дээд сургуулийн багш болон оюутны зөвлөлтэй хамтран уулзалт зохион байгуулсан юм. Энэ үеэр Эрүүл мэндийг дэмжих төвийн дарга Ж.Энхзулаас зарим зүйлийг тодруулав.*

**-Энэ жил ямар арга хэмжээ зохион байгуулж байна вэ. Ямар арга хэмжээг зонхилон зохион байгуулахаар төлөвлөж байна вэ?**

-Монгол Улсын Засгийн газар болон Эрүүл мэндийн яамны төлөвлөгөө, стратегид тусгагдсан бэлгийн замын халдварт өвчин буюу ХДХВ-ын эрсдлээс сэргийлэх талаар өсвөр үе, залуучуудад зориулсан мэдээлэл сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх чиглэлийн хүрээнд өнөөдрийн сургалт болж байна. Ер нь 15-25 насны залуучуудад эрүүл мэнд болон ХДХВ-ын талаархи зөв мэдээлэл, сурталчилгааг түгээхийн тулд Скайтел, Юнител, Мобиком компаниар дамжуулан 395 мянган хэрэглэгчдэд мессэжийг илгээнэ. Мөн мэдээлэл, сурталчилгааны материалуудыг түгээхээр төлөвлөсөн. Сургуулийн оюутны дотуур байранд сургалт явуулна. Өнөөдөр Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулийн эмч нарын уулзалт болж байна. Энэ уулзалтаар бид 150 гаруй эмч болон оюутны холбооны төлөөлөлтэй хамтран ХДХВ-ын чиглэлээр хийх үйл ажиллагаагаа хэлэлцэх гэж байна. Ингэснээр оюутны холбоод нь сургуулийн эмч, эмнэлгийн ажилтнаа дэмждэг, хамтарч үйл ажиллагаа зохион байгуулдаг сүлжээг бий болгох гэж байна. Өөрөөр хэлбэл, сургуулийн эмч нарын фэйсбүүк хаяг нээгээд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн сургуулийн эмч нартай хамтраад илүү ойр ажиллах боломж нээгдэх юм.

**-Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн хүн амд эрүүл мэндийн талаархи зөвлөгөө зөвлөмж хүргэдэг шүү дээ. Энэ чиглэлээр ирэх онд үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөж байна вэ?**

-Ер нь оюутны "Эрүүл мэндийн дэмжих өдөр"-ийг жил бүр Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулдаг. Мөн арванхоёрдугаар сарын 1-нд ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх дэлхий нийтийн өдөр байдаг. Тиймээс энэхүү өдрийг тэмдэглэн, олон үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөөд байна. Тэр үйл ажиллагааны эхлэл нь энэхүү сургалт гэж ойлгож болно. Их дээд сургуулийн эмч нартай энэ удаад уулзлаа. Мөн бид 21 дүгээр сургууль дээр Ерөнхий боловсролын сургуулийн эмч, оюутны холбоонд сургалт, уулзалт зохион байгуулна. Бид зөвхөн ХДХВ-ын талаархи мэдээлэл гэлтгүй хүн амыг шууд үхэлд хүргэж буй бөөрний дутагдал, тархинд харвалт, зүрхний шигдээс зэрэг асуудлаар иргэдэд дараах хуваарийн дагуу уулзалт сургалт хийж, хүн амд өвчлөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч, брошур хуудас тараах юм. Түүнчлэн энэ сарын 24-нд өглөө 11:30-12:30 цагийн хооронд мэдээлэл сурталчилгааны материал тараана. Тэгэхээр олон төрлийн сургалт, уулзалтыг цаашид хийхээр төлөвлөсөн.

**-Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд чиглэсэн судалгааг танайхаас гаргадаг уу?**

-Өсвөр үе, залуучуудын дунд явуулсан мэдлэг хандлагын судалгаанаас харахад нийт залуучуудын 50 орчим хувь нь эрүүл мэндийн мэдээллийг хаанаас авахаа мэддэггүй гэж хариулсан байдаг. энэ маань юу гэж байна вэ гэвэл залуучууд мэдээлэл сурталчилгаагаар дутмаг байна. Тэдэнд мэдээллийг сайн хүргэх ёстой, мэдээллийн эх сурвалжуудыг сурталчилж өгөх ёстой юм байна гэж бид үзсэн.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХИЙГ АНХААРУУЛЛАА

Цаг агаарын байдлын улмаас орон сууц халаалт, гэр хорооллын галлагаа эхэлснээр ахуйн гал түймрийн гаралт ихсэх хандлагатай байгааг холбогдох газраас мэдээллээ. Тэдний хэлж буйгаар он гарснаас хойш улсын хэмжээнд 3282 удаагийн объектын гал түймэр бүртгэгдсэн байна. Харин өнгөрсөн сарын байдлаар улсын хэмжээнд нийт 662 удаагийн гал түймэр гарсан гэнэ. Тиймээс пийшин зуухны галын аюулгүй байдлыг хангуулах, зориулалтын бус түлш түлэхгүй байх, үнс нурмыг тагтай төмөр саванд хийх, стандарт хангасан разетка, утас хэрэглэх, бага насны хүүхдийг харгалзах хүнгүй үлдээхгүй, цоожлохгүй байх зэргийг Онцгой байдлын ерөнхий газраас иргэдэд анхааруулав.

## "Ногоон гэрэл, цагаан шугам-2017" тэмцээн болов




*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

"Ногоон гэрэл-цагаан шугам-2016" тэмцээн 35 дахь жилдээ өчигдөр зохион байгуулагдлаа. Энэ удаагийн тэмцээнд нийслэлийн долоон дүүрэг, орон нутгаас нэг баг оролцсон. Улсын хэмжээнд зохиогддог ч энэ жил цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлаас үүсч Баян-Өлгий аймгаас бусад аймгийн сурагчид оролцох боломжгүй болсон байна. Хүүхдүүд ихэвчлэн сургууль, цэцэрлэг явах, гэртээ харих замдаа осолд өртдөг байна. Тиймээс "Ногоон гэрэл-цагаан шугам" тэмцээн хүүхдүүдийн дунд гарцтай газраар зам хөндлөн гарах, бага насны хүүхдүүд асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцохгүй байх зэрэг замын хөдөлгөөний мэдлэгээ дээшлүүлэхэд чухал гэдгийг оролцогч хүүхдүүд хэлж байв. Чингэлтэй дүүргийн 72 дугаар сургуулийн сурагч н.Баттүшиг "Манай ангийн хүүхдүүд бага ангийн хүүхдүүдийг зам гарахад нь тусалдаг. Хүүхдүүд бид ногоон гэрэл, цагаан шугамтай газраар зам гарах хэрэгтэй.

Ялангуяа хальтиргаа, гулгаатай байгаа энэ үед заавал гарцаар гарч байгаарай" гэж зөвлөсөн юм. Мөн замын хөдөлгөөнд оролцоход хүүхдүүдээс илүү томчуудын анхаарал болгоомж, дүрэм зөрчдөг байдал нь хүүхдүүдэд муу үлгэр болдог гэдгийг ч онцолж байлаа. Жил бүр зохиогддог энэхүү тэмцээн нь хүүхдүүдэд багаас нь замын хөдөлгөөний дүрмийг таниулах, хэвшүүлэх, бага насны хүүхдүүдийг зам тээврийн ослоос сэргийлэх, замын хөдөлгөөнд соёлтой оролцуулахад чухал үүрэгтэй. Замын цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах мэргэжилтэн ахлах дэслэгч Г.Отгонтамир "35 дахь жилдээ зохиогдож байгаа энэхүү тэмцээн жил бүр оролцох хүүхдүүдийн хүрээ тэлж байгаагийн хирээр хүүхдүүд замын хөдөлгөөнд идэвхитэй оролцоход чухал ач холбогдолтой болдог. Үүнээс гадна Замын цагдаагийн газраас сургуулиудтай хамтран ХАБ /Хөдөлгөөний аюулгүй байдлын ажилтан/ ажиллуулж эхэлснээс сургуулийн орчинд хүүхдүүд зам тээврийн осолд өртөх нь буурах хандлагатай байгаа.

Гэсэн хэдий ч хүүхдүүдээс илүү эцэг эхчүүд, асран хамгаалагчдын анхаарал илүү байх ёстой" гэв. Мөн энэ оны аравдугаар сарын байдлаар зам тээврийн ослоор 48 хүүхэд нас барж, 199 хүүхэд бэртсэн байна. Осолд өртсөн хүүхдүүдийн 53,1 хувь нь харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцсон гэсэн тоон мэдээлэл байна. Дашрамд сонирхуулахад, "Ногоон гэрэл-цагаан шугам-2016" тэмцээн энэ жил 35 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд Замын цагдаагийн газрын 80 жилийн ой тохиож байгаагаараа онцлогтой ажээ.

## 64.4 кг мөнгөн ус борлуулахыг завджээ

"ТБД андууд" дэлгүүрийн урд зам дээр Замын цагдаагийн газрын алба хаагчид энэ сарын 21-нд тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийжээ. Шалгалтын үеэр сэжиг бүхий тээврийн хэрэгслийг саатуулан шалгахад "Range Rover" маркын автомашинаар 64.4кг мөнгөн ус бусдад худалдан борлуулахаар тээвэрлэж авч явсаныг таслан зогсоосон байна. Тодруулбал, их хэмжээний мөнгөн усыг О, Ц нар хууль бусаар авч явсныг сатуулан Монгол Улсын Эрүүгийн хуулийн 214.1.1-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгажээ. Мөн гэмт этгээдүүд дунд ОХУ-ын нэг иргэн байсан байна. Уг хэргийг Баянгол дүүргийн цагдаагийн I дүгээр хэлтэс шалгаж байгаа ажээ. Түүнчлэн эрүүгийн хуулийн 2141.1.Химийн хорт болон аюултай бодисыг зөвшөөрөлгүйгээр экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, хадгалах, худалдах, худалдан авах, тээвэрлэх, ашиглах болон бусдад дамжуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ хэмээн заасан байдаг юм.

## Гэр хорооллыг хөгжүүлэх сэдвээр хэлэлцүүлэг зохиов

Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газар, Азийн Хөгжлийн банкны "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-тэй хамтран өчигдөр "Гэр хорооллыг шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөхөд төрийн болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоо" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Барилга хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч П.Баярхүү, Монгол Улсад суугаа АНУ-ын Элчин сайдын яамны Эдийн засаг, худалдааны албаны дарга Жон Б.МакДаниел, БНХАУ-ын Хөгжлийн банкны хамтын ажиллагааны дарга Чен Мао Хэ болон холбогдох албаны хүмүүс оролцож санал бодлоо солилцов. Энэ үеэр нийслэлийн Засаг даргын орлогч П.Баярхүү "Бид иргэддээ чирэгдэл бага, хямд өртөг бүхий эрэлтэд нийцсэн, зөв зохион байгуулалттай байх дахин төлөвлөлтийн аргуудыг хэрэглэхээр зорьж байна. Өнөөдрийн хэлэлцүүлэгт салбарын сайд, нийслэлийн удирдлагууд, НИТХ-ын төлөөлөгчид, хувийн хэвшлийнхэн оролцож байна.

Бид бодлогоо нэгтгэж, нэг нэгнээ дэмжин хамтарч ажиллах нь чухал" гэсэн юм. Харин Азийн хөгжлийн банкны Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн төслийн зохицуулагч Д.Авирмэд "Эхний ээлжинд бид Баянхошуу, Сэлбэ дэд төвийг бий болгохоор ажиллаж байна. Иргэдийн оролцоотойгоор газар шинэчлэн зохион байгуулж, төлөвлөж шинэ дэд төв бий болгох ажлыг эхлүүлээд явж байгаа. Төслийн хувьд Баянхошуу дэд төвд нийт 152 га газарт шинээр төлөвлөлт хийж, орчин үеийн шийдэл бүхий инженерийн байгууламж бий болгохоор ажиллаж байна" хэмээсэн. Хэлэлцүүлэгт оролцогчид тулгамдаад байгаа асуудлуудаас хамтдаа гаръя гэсэн санаачлагыг дэвшүүлээд байна. Мөн хувийн хэвшлүүдийн зүгээс шинэ гарц боломжуудын талаар холбогдох албаны хүмүүст танилцуулсан юм.

## Ирэх баасан гарагт дугаарын хязгаарлалт үйлчлэхгүй

УИХ-ын чуулганаар энэ сарын 18-нд Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж, арваннэгдүгээр сарын 26-ны өдрийг Бүгд найрамдах улс тунхагласны баярын өдөр болгон тэмдэглэн бүх нийтээрээ амрахаар шийдвэрлэсэн. Гэвч энэ жилийн арваннэгдүгээр сарын 26 амралтын өдөр буюу бямба гараг таарч байгаа юм. Тиймээс амралтын өдрийг ажлын өдөрт шилжүүлж ирэх баасан гарагт амрахаар болсон. Үүнтэй холбогдуулан ирэх баасан гарагт дугаарын хязгаарлалт үйлчлэхгүй юм байна.

## Согтуу үедээ гадаа унтаж, осгожээ

Хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гадаа гудамж, талбайд унтаж, улмаар осгох тохиолдол ихэсч буй талаар Цагдаагийн ерөнхий газраас анхааруулав. Тодруулбал, өнгөрсөн мягмар гарагт "ГССҮТ-д "Бөмбөгөр" худалдааны төвийн урд талбайгаас осгосон байдалтай хүн ирж хэвтэн эмчлэгдэж байна" гэсэн мэдээлэл цагдаагийн газарт иржээ. Дуудлагын дагуу шалгахад 46 настай эрэгтэй Г нь согтуурч осгосон байдалтай Яаралтай түргэн тусламжийн 103-аар хүргэгдэн ирсэн аж. Одоогоор түүний оршин суугаа хаяг тодорхойгүй бөгөөд "Түлэнхийн тасаг"-т хэвтэн эмчлэгдэж байгаа гэнэ. Тус хэргийг Чингэлтэй дүүргийн I дүгээр хэлтэс шалгаж байна.

PHOTO NEWS

*Нийслэлийн удирдлагууд шуурхай хуралдаанаар Нийслэлийн цэргийн штабын дарга, хурандаа Ж.Болдбаатар цас цэвэрлэх хотын даргын уриалгад цэргийн анги байгууллагууд нэгдэж буйг дуулгасан юм. Тухайлбал өнгөрсөн өдөр Хан-Уул дүүрэг Яармагийн гүүрнээс Нисэхийн уулзвар хүртэлх замд 013, 017, 089, 120 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид цас цэвэрлэсэн байна. Тухайн хэсэгт цэвэрлэгээ хийсэн цэргүүдэд иргэд халуун аарц чацарганаар үйлчилжээ.*





*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

# ЭРҮҮЛ МЭНД



Оюунаа эмчийн булан

# ЭРДЭС, АМИН ДЭМ ЯМАР ҮҮРЭГТЭЙГ ТА МЭДЭХ ҮҮ?




## ЭРДЭС, АМИН ДЭМ ГЭЖ ЮУ ВЭ?

Эрдэс, амин дэм эсийн доторхи биологийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүний биед эрдэс, амин дэм дутагдвал эрхтэн тогтолцооны хэвийн үйл ажиллагаа алдагдаж, улмаар архаг эмгэг үүсгэх эрсдэлтэй. Тэр дундаа жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүд, нярай, бага, өсвөр насныхан, цагаан хоолтон, өндөр настнууд, архаг хуучтай хүмүүст илүү эрдэс, амин дэм дутагдалтай байдаг байна. Улс орны эдийн засгийн байдал, газарзүй, цаг агаар, зан заншил, хоол хүнсний бүтэц ялгаатай учир эрдэс, амин дэмийн хэрэгцээ, хоол тэжээлээр авч байгаа хэмжээ харилцан адилгүйг олон улсад хийгдсэн судалгаанаас харж болно. Мөн биед шаардагдах хэмжээ нь тухайн хүний нас, хүйс, биеийн жин, өндөр, улирал, ажлын нөхцөл гэх мэт олон хүчин зүйлээс хамааран өөрчлөгдөнө. Жирэмсэн үед эмэгтэй хүний биед физиологийн олон өөрчлөлтүүд явагддаг. Эхийн хэвлийд ураг хэвийн өсч бойжиход шаардагдах хүчилтөрөгч, уураг, нүүрс ус, өөх тос, эрдэс давс, амин дэм эхийн цусаар дамжин жирэмслэлтийн хэвийн үйл ажиллагаа явагдаж, ураг хэвийн өсөх нөхцөл хангагддаг байна.

## ЭРДЭС ЯМАР ҮҮРЭГТЭЙ ВЭ. ЭРДЭС ДУТАГДАХ ҮЕД ЯМАР ШИНЖ ИЛЭРЧ БОЛОХ ВЭ?

ЭРДЭС бодис болох кальци, натри, кали, хлор, магни, төмөр, иод, зэс, цинк зэрэг нь эд, эсийн бүтцийн материал, ус, давсны солилцоог зохицуулах, хүчил шүлтийн тэнцвэрийг хадгалах, ферментүүдийн үйл ажиллагааг хангах үүрэг гүйцэтгэдэг.Хоол хүнсээр авах эрдэс, амин дэм дутагдахад жирэмсэн эхийн бодисын солилцоо, ихсийн үйл ажиллагаа хямарч улмаар ургийн хэвийн өсөлтөд сөрөг нөлөөтэй.

**КАЛЬЦИ:** Хүний кальцийн нэг хоногийн хэрэглээ нь дунджаар 800 мг байдаг. Нийт хүний биед байх ёстой кальцийн 99 хувь нь яс, шүдэнд, үлдсэн нь эсийн гаднах шингэн, эдэд агуулагддаг. Жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүд, хэвлий дэх ургийн яс, шүд, зүрх, мэдрэл, булчингийн хэвийн хөгжлийг хангах, зүрхний хэмнэл, цусны бүлэгнэх үйл ажиллагаа, хоргүйжүүлэх, саармагжуулах, эс хоорондын холбоос эд үүсэхэд хангахад кальци чухал үүрэгтэй. Ураг бүрэлдэн тогтох үеэс ургийн ясжилтын суурь тавигддаг. 1500-2000 мг кальцийг өдөрт хүнсний нэмэлтээр хэрэглэж байсан эмэгтэйчүүд дунд судалгаа хийхэд жирэмсний хожуу үеийн хордлогоор өвдөх, хугацаанаасаа өмнө төрөх магадлал бага байсан байна. Кальци дутагдахад гар, хөл бадайрч, хумс хугарамтгай болох, яс сийрэгжиж, хэврэгшиж, хугарах, толгой өвдөх, зүрх дэлсэх, даралт ихдэх, нойргүйдэх, цочромтгой болох, булчин шөрмөс татах, тайван бус болох, шүд хэврэгших, хугарах зэрэг шинж тэмдэг илэрдэг. Хийжүүлсэн ундааны найрлага дахь фосфор нь кальцийн шимэгдэлтийг бууруулдагучир кальци ихтэй хүнс хэрэглэх шаардлагатай. Кальцийг биед шаардагдах хэмжээнээс багаар хэрэглэвэл бие махбодь хэвийн үйл ажиллагаагаа хангахын тулд кальцийг яснаас авч хэрэглэдэг.

**КАЛИ, НАТРИ:** Натри, кали эсийн гаднах шингэний хэмжээ, осмос даралтыг зохицуулна. Кали нь эд эсийн шингэнийг тэнцвэржүүлэх, булчин, зүрхний хэвийн ажиллагааг хангахад оролцоно. Натри нь цусны даралт тогтовортой байлгах, хүчил шүлтийг тэнцвэржүүлэх, биеийн шингэний алдагдлаас хамгаалах, булчингийн үйл ажиллагааг хангана. Хоногийн натрийн хэрэгцээ 200-500 мг байна. Кали, натри, магни, хлор, кобальт, зэс зэрэг микроэлемэнтүүд ургийн хэвийн өсөлт, төрөлт, сүүжих үйл явцад тодорхой үүрэгтэй. Калий төмс, алим, үзэм зэрэг жимсэнд илүү агуулагддаг. Калийн хоногийн дундаж хэрэгцээ нас насанд өөр өөр байна. Жирэмсэн, хөхүүл эмэгтэйд 5100 мг байна. Кали дутагдахад арьс хуурайсч, гүйлгэх, шөрмөс татах, зүрхний хэм алдагдах, хавагнах, нойргүйдэх, өөх тос хуримтлагдах, цусны даралт ихсэх зэрэг шинжүүд гарна. Тун хэтрүүлсэн тохиолдолд зүрхний хэм алдагдах, булчин сулрах , зүрхний үйл ажиллагааны доголдлын шинжүүд илэрнэ.

**ТӨМӨР:** Дунджаар хүний төмрийн хоногийн хэрэгцээ 15-20 мг байдаг байна. Төмөр нь цусан дахь гемоглобины бүтцэд орж, эд эсэд хүчилтөрөгчийг зөөвөрлөх үүрэгтэй. Жирэмсэн эмэгтэйн хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний төмрийн агууламж жирэмсэн биш эмэгтэйд шаардагдах хэмжээнээс дунджаар 10 дахин их байх шаардлагатай. Учир нь ургийн өсөлт хөгжил хэвийн явагдахад төмрийн хэрэглээ нэмэгддэг. Төмөр нь улаан эс, гемоглобины үүсгэж, идэвхтэй хүчилтөрөгч уураг нийлүүлэх цусны улаан эсийг төлжүүлэхэд оролцоно. Төмөр дутагдлын үед хоолны дуршил буурна, цус багадалт үүсэж, ургийн өсөлтийн саатал, зулбах, дутуу төрөх, бага жинтэй хүүхэд төрөх магадлалтай. Төмөр хүнсний ногоо, гүзээлзгэнэ, интоор, чангаанз, усан үзмийн дарс, байцаа, сонгино, улаан лоольд агуулагдах тул хоол тэжээлээр тодорхой хэмжээний хэрэгцээ хангагдах боломжтой. Хоол хүнсээр авах аминдэм С, жимс жимсгэнийг хэрэглэснээр төмрийн шимэгдэлт сайжирна.

**ИОД:** Хоногийн хэрэгцээ нь 100-120 мкг. Хүний нарийн гэдэснээс элгэнд шимэгдэнэ. Бамбай булчирхайн үйл ажиллагаанд оролцож, тироксин үүсэх оролцдог. Жирэмсэн үед иодын хэрэгцээ харьцангүй нэмэгддэг. Иод нь ургийн өсөлт хөгжлийн хангахад чухал үүрэгтэй. Иод дутагдахад бамбай булчирхай томорч, ялгарах даавbooрын хэмжээ бага болж, хүнсний бүтээгдэхүүний иодын агууламж бага байдаг учраас зарим тохиолдолд иоджуулсан давс хэрэглэх замаар нэмэлт хэрэгцээг хангадаг.

**АМИН ДЭМ:** Бодисын солилцоо хэвийн явагдахад АМИН ДЭМҮҮД чухал үүрэгтэй. Үүнд С, А, В1, Д, Е, К, РР чухал үүрэгтэй. С амин дэмийн хэрэгцээ ердийн үеийнхээс 2-3 дахин ихсэж, үр хөврөлийн бүрхүүл, ихэс үүсэх, ургийн хэвийн хөгжлийг хангана. А амин дэм ургийн өсөлт, В1 мэдрэлийн үйл ажиллагааг зохицуулахад, Д тулгуур эрхтэн, ясны хөгжилд, Е жирэмслэлт хэвийн явагдах нөхцөлийг тус тус хангахад оролцдог. Жирэмсэн үед цусны эргэлтийн тогтолцоонд өөрчлөлт гарч, зүрх цусаа шахах үйл ажиллагаа ердийн үеийнхээс 30-50 хувь нэмэгдэж, цусны сийвэнгийн эзлэхүүн нэмэгдэж, цусны улаан эсийн тоо харьцангүй цөөрснөөр уураг, микроэлэмент багасдэг байна. Эхийн биед жирэмслэлттэй холбоотой эрдэс, амин дэмийн хэрэгцээ ихэсдэг. Шаардлагатай эрдэс, амин дэмийг ураг эхийн цусны эргэлтээр дамжуулан авна. Тиймээс хүний хөгжлийн нарийн үе шат хөврөл, ургийн хөгжлийн үед эрдэс, амин онцгой үүрэгтэй учраас жирэмсэн үеийн эхийн хооллолт маш чухал асуудал байдаг.

**В:** В1,В2,В3,В5,В6 багтана. В1 дутагдлын үед хоолны дуршил буурах, жин хасагдах, цочромтгой, тайван бус, хүнд хэлбэрийн дутагдлын үед булчин сулрах, хавагнан зүрхний үйл ажиллагаа алдагдах зэрэг шинж илэрч болно. В1 гурвалжин будаа, гахай үхрийн мах, шинэхэн вандуй, буурцаг, талх, их агуулагддаг байна.

**А:** Амин дэм нь эрхтэн, эд хэвийн өсөлтөд чухал ач холбогдолтой. Арьс, салтын нөхөн төлжих үйл ажиллагааны явцад чухал үүрэг гүйцэтгэдэг. дархлаа идэвхжүүлэх, нүдний хараа, сонсгол, үнэрлэх, хүрэлцэх эрхтэн зөв үйл ажиллагаа, харааны пигмент үүсэх, өөх тос, уургийн нийлэгжилт нь бодисын солилцоонд оролцдог. Жирэмсэн үед цусны улаан эсийг нөхөн дэмжих, амьсгалын зам, нарийн гэдэсний салстын үйл ажиллагааг хангана. Загасны тос, элэг, бөөр, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүнд агуулагдана. Жирэмсний үед витамин А илүүдэл төв мэдрэлийн тогтолцоо, зүрх, бөөр, нөхөн үржихүйн ургийн эрхтэн, мөчид нь гажиг үүсгэх эрсдэлтэй.

**Д:** Биед хоол тэжээлийн хамт, нарны гэрлийн нөлөөгөөр үүсч, ясны солилцоонд оролцон сийрэгжилтээс хамгаална. Д амин дэм дутагдсанаас хоол боловсруулах замаар кальци, фосфорын шимэгдэлт буурч, бие махбодын яс зөөлрөх өвчин юм. Д амин дэмийн дутагдлын үед умайн гөлгөр булчинд нөлөөлж ураг өсөлтгүй болох, яс үүсэн хөгжих үйл ажиллагаа алдагдан яс зөөлрөх, мөчид тулгуур эрхтний хөгжлийг гажиг үүсэх эрсдэлтэй байдаг.

**ФОЛИЙН ХҮЧИЛ:** Ургийн мэдрэлийн системийн эсүүд хөгжихөд оролцоно, эд эс, үр хөврөлийн болон ургийн хэвийн өсөлт, цусны улаан эс, цусны цагаан эс үүсэхэд чухал үүрэгтэй. Фолийн хүчлийн дутагдлын үед мэдрэлийн гуурс гажиг, тархи хөгжихгүй байх эмгэгээс гадна хүүхдийн оюун ухааны хөгжил саатна Ургийн тархи нугасны ивэрхий үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор жирэмсэн эмэгтэйчүүд эмчийн хяналтын доор хэрэглэдэг.

**К:** Цус бүлэгнүүлэх тогтолцоонд чухал үүрэгтэйгээс гадна жирэмсэн, төрөх үед чухал ач холбогдолтой юм. К зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх хамгийн чухал амин дэмүүдийн нэг бөгөөд тодорхой хэмжээгээр хэрэглэж байсан хүмүүсийн дунд хийсэн судалгаагаар зүрх судасны нас баралтын эрсдэл багатай гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна. К дутагдсанаас цус бүлэгнэх үйл ажиллагаа алдагдаж цус гарамтгай, цус багадалтын шинж илэрч, ясны сийрэгжилт явагдана. К амин дэм навчит ногоон хүнсний ногоо, улаан лооль, цэцэгт байцааны, хөх тариа, улаан буудайнд агуулагддаг байна.

**АНХААРУУЛГА:** Хүний биед эрдэс, амин дэм хэрэгцээ ИЛҮҮДЭХ, ДУТАГДАХ аль аль нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй учраас та бүхэн зөв зохистой, эрдэс, амин дэмийн тэнцвэржүүлсэн хоол хүнс хэрэглэх хэрэгтэй. Гэвч зөв хооллолт гэсэн ойлголт нь өөр газар орны онцлогт суурилагдсан хооллолтыг сохроор дагаж мөрдөх гэсэн ойлголт биш гэдгийг анхаарах хэрэгтэй. Хэрвээ та жирэмсэн, эсвэл жирэмслэхээр төлөвлөж байгаа бол эхлээд цусанд байх эрдэс, амин дэмийг тодорхойлуулсны дараа нэмэлтээр хэрэглэх эсэхээ шийдэх нь таны жирэмсний явц болон ирээдүйн хүүхдийн хэвийн өсөлт хөгжилтөд чухал гэдгийг анхаарах хэрэгтэй.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## Эрүүл мэндийн даатгалын санг хүртээмжтэй болгох талаар санал солилцов

Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат болон холбогдох албаны хүмүүс Улсын нэгдүгээр төв эмнэлэгт ажиллаж, эрүүл мэндийн даатгалаар санхүүждэг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд тулгамдаж байгаа асуудлуудын талаар тус эмнэлгийн удирдлагуудтай санал солилцлоо. Мөн уулзалтын өмнө сайд нар тус эмнэлэгт үйлчлүүлж буй иргэдийн саналыг сонсож, шаардлагатай эмчилгээг нь хүлээгдэл, чирэгдэлгүй үзүүлэхийг холбогдох эмч нарт нь даалгасан. Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг эрүүл мэндийн салбарын бодлого нь даатгалтайгаа уялдаж явах нь зайлшгүй гэдгийг хэлээд, эрүүл мэндийн даатгалын тодорхой хувийг салбарын ажилчдын цалин хөлс, урамшуулал, бүтэц орон тооны асуудлыг шийдвэрлэхэд, мөн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх зэрэгт зарцуулах нь зүйтэй юм гэв.

## Томуугийн эсрэг вакцин ирлээ



Эрүүл мэндийн яамнаас томуу, томуу төст өвчин цаашид нэмэгдэх хандлагатайг сануулсан. Тэгвэл өчигдөр Засгийн газраас БНХАУ руу захиалсан 78 мянга гаруй хүн тун томуугийн эсрэг вакцин ирж байгааг эх сурвалж мэдэгдлээ. Цаашид вакцины хүрэлцээг нэмэгдүүлж, НҮБ-ын хүүхдийн сангийн шугамаар 33 мянган хүн тун вакциныг Франц улсаас орж ирэх юм. Мөн АНУ-ын өвчний хяналт, сэргийлэлтийн төвийн тусламжийн шугамаар олгох гэрээний дагуу 40 мянга гаруй хүн тун вакцин нэмэгдэнэ. Томуугийн вакцинд зургаан сартайгаас дээш насны бүх хүн хамрагдах боломжтой бөгөөд вакцин хийлгэж хүн эрүүл байх, сарын дотор ямар нэгэн вакцин хийлгээгүй, өндөгний харшилгүй байх ёстой. Сүүлийн үед эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлж буй нийт иргэдийн улсын хэмжээнд 4.7 хувь томуугийн болон амьсгалын замын өвчин, нийслэлд 5.8, аймгуудад дөрөв орчим хувьтай байгаа аж. Хүүхдийн дуудлагын 30 хувь, насанд хүрэгчдийн дуудлагын хувьд хоёр хувийг энэ төрлийн өвчлөл эзэлж байгаа юм. Улсын хэмжээнд нийт орны 11 орчим хувь дээр амьсгалын замын уушиг, амьсгалын замын цочмог өвчтэй 700 орчим хүн хэвтжээ.


## ЭЛСЭЛТИЙН ЗАР

“Зохиомж” дээд сургууль 2016-2017 оны хичээлийн жилд дараах мэргэжлүүдээр өдөр, орой, эчнээ, хөрвөх ангид 4 жил, 2.5 жил, 1.5 жилийн бакалаврын ангид нэмэлт элсэлт авна.

1. Телевизийн сэтгүүлч, зураглаач
2. Кино, драмын жүжигчин
3. Кино, телевизийн найруулагч
4. Бага ангийн багш
5. Сургуулийн өмнөх боловсролын багш
6. Эрх зүй
7. Санхүү, банк
8. Нягтлан бодох бүртгэл, татвар
9. Гааль, гадаад худалдаа

**Жич:**
- IX/1 –нээс хойш судалсан хичээлүүдийг нэмэлт цагаар нөхүүлнэ
-Өнгөрсөн хугацаанд өөр сургуульд судалсан хичээлүүдийн дүнг тооцож үргэлжлүүлэн суралцах боломж олгоно.

**Сэтгүүл зүй, Урлаг судлал, Бизнесийн удирдлага ангиудад магистрын элсэлт авна.**
**Холбоо барих утас: 70155585, 91111187, 99608440, 80818021**


## Хүчингүйд тооцов

9011247144 Улсын бүртгэлийн дугаартай 5402816 регистрийн дугаартай Топ айди ХХК-н улсын бүртгэлийн гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

2020793 регистрийн дугаартай “Халиун трейд” ХХК-н НЗД-н 2009 оны 90 тоот захирамжтай газрын гэрчилгээ, гэрээний хамт гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов

Сүхбаатар Дүүргийн 71-р сургуулийн 2007013 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн тул хүчингүйд тооцов

Ч.Баянжаргалын (регистрийн дугаар: ФЖ62031202) өмчлөгчийн Ү-2205016024 Улсын бүртгэллийн дугаартай байрны гэрчилгээг гээсэн тул хүчингүй тооцов.

ЦАГ ҮЕ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

Э.ТУУЛ



# “ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИ-2016” ҮЗЭСГЭЛЭНГИЙН ШИЛДГҮҮД ӨНӨӨДӨР ТОДОРНО

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Шинжлэх ухааны салбарын эрдэмтэн судлаач, зохион бүтээгчдийн туурвисан шилдэг бүтээлүүд нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулж буйг “Шинжлэх ухаан, технологи, инноваци-2016” үзэсгэлэнгийн үеэр БСШУС-ын сайд Ж.Батсуурь онцлов. Шинжлэх ухааны салбарын шинэ технологи, бүтээл, загварыг олонд дэлгэдэг тус үзэсгэлэнгийн нээлт өчигдөр Уран зургийн галерейн үзэсгэлэнгийн танхимд боллоо. Үзэсгэлэнг нээж, БСШУС-ын сайд Ж.Батсуурь “Монгол Улсын Засгийн газраас Үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, шинжлэх ухааны парк байгуулах, түүний эхлэл болсон гарааны компанийг байгуулж ажиллах эрх зүйн орчинг 2014 онд бүрдүүлж өгсөн.

Энэ үзэсгэлэнд манай эрдэм шинжилгээний байгууллагуудын дэргэд байгуулсан 20 гарааны компани бүтээгдэхүүнээ дэлгэн танилцуулж байгаа нь энэ жилийн үзэсгэлэнгийн онцлог нь юм. 2015 оны байдлаар манай эрдэмтэн судлаачид нийт 9735 бүтээл туурвиж, үүнээс дотоодод 7624, гадаадад 2111 бүтээл хэвлүүлснээс 952 ном, 4519 эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлсэн байна. Шинэ бүтээлийн патент 34, ашигтай загварын гэрчилгээ 29, зохиогчийн эрхийн гэрчилгээ 45-ыг авчээ. 2016 оны статистик хараахан гараагүй ч гэсэн 2015 оныхоос дутахгүй үр дүнтэй байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Эдгээр бүтээл нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулсаар байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна” хэмээсэн. Уг үзэсгэлэнд эрдэмтэн судлаачдын онолын болон хэрэглээний судалгаа, шинжилгээний ажлын үр дүн, шинээр туурвисан ном, товхимол, археологи, палеонтологийн олдвор, хүн мал, амьтны урьдчилан сэргийлэх шинэ эм бэлдмэл, вакцин, оношлуур, биологийн идэвхит бүтээгдэхүүн, тэжээлийн ургамал, шинэ сорт, үр тариа, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, ургамал хамгааллын бэлдмэл, бордоо, байгаль орчинд халгүй технологи, ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүн, мэдээллийн технологи зэрэг 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг дэлгэжээ.

Мөн 2016 онд шинжлэх ухаан технологийн 73, цөмийн технологийн 8, инновацийн 74, суурь судалгааны 163, гадаадтай хамтарсан 74, докторын дараах судалгааны 21, ШУА-ийн 33 грант нийт 400 гаруй төслийн үр дүнг тайлагнаж байна. ШУА-ийн палеонтологи, геологийн хүрээлэнгээс эвэрт үлэг гүрвэлийн толгойн яс, махан идэшт тэмээн хяруул маягийн үлэг гүрвэлийн яс зэрэг ховор бүтээлийг үзэсгэлэнд дэлгэжээ. Энэ бүтээл нь олдворын эх хувь биш бөгөөд олдворыг олж, судалсны дараа хэвийг нь авч цутгасан хуулбар юм. Палеонтологийн олдворыг оргинал хувилбараас хуулбарлах технологи нь Монголын хувьд шинэ зүйл хэмээн судлаач хэлж байна. Судалгаа шинжилгээний хамтын ажиллагааны хүрээнд Японоос оруулж ирсэн материалаар хийсэн анхны дээжээ дэлгэж байгаа нь энэ аж.

Харин ХСҮТ-өөс “Элэгний анхдагч өмөнтэй өвчтөнд амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс заслыг монгол нутагшуулах нь” төслийг танилцуулав. Тус төвийн Элэг, цөс, нойр булчирхайн тасгийн эрхлэгч Ж.Чинбүрэн хэлэхдээ, “ХСҮТ-д элэгний хавдартай, хатуурал хүнд үедээ орсон, элэг шилжүүлэн суулгах шаардлагатай иргэдийн тоо 100 давaад байна. Хагалгаа хийлгүй хойшлох тусам хүлээж буй өвчтөнүүдийн хавдар томорч хагалгаа хийж чадахгүйд хүрч байгаа нь сэтгэл түгшээж байна. Тиймээс аль болох мэс заслыг хурдан хийхийн төлөө баг хамт олон ажиллаж байгаа. Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хагалгааны өрөөг тусгайлан элэг шилжүүлэн суулгахад зориулан бэлдэж байна. Ирэх сарын 20-ны үеэр хагалгааг хийхээр төлөвлөж байсан бол энэ ажил хойшилж мичин жилдээ багтаан хавдартай хүмүүст элэг шилжүүлэн суулгах мэс заслыг хийнэ. Төсөл 2017 онд хэрэгжиж дуусна” гэв.







...Уламжлалт талхны орцыг модны бионүүрсээр баяжуулан хийсэн эрүүл мэндийн бүтээгдэхүүн болох талх, печень нь гэдэс дүүрэхийг зогсоох, хордлого болохоос сэргийлэх, биеийн холестриний хэмжээг зохицуулах, хоол боловсруулах эрхтний тогтолцоог сайжруулах, бөөрний үйл ажиллагааг дэмжих давуу талтай...

Түүнчлэн ХААИС-ийн Инноваци, бизнес хөгжлийн төвөөс бионүүрсээр баяжуулсан эрүүл мэндийн хүнсний бүтээгдэхүүнийг дэлгэсэн байв. Уламжлалт талхны орцыг модны бионүүрсээр баяжуулан хийсэн эрүүл мэндийн бүтээгдэхүүн болох талх, печень нь гэдэс дүүрэхийг зогсоох, хордлого болохоос сэргийлэх, биеийн холестриний хэмжээг зохицуулах, хоол боловсруулах эрхтний тогтолцоог сайжруулах, бөөрний үйл ажиллагааг дэмжих давуу талтай. Энэ талх, печень нь дэлхий нийтэд хамгийн үнэтэй тансаг хэрэглээ хэмээн зочид буудлууд өглөөний хоолны цэсэндээ оруулдаг. Худалдаанд байгаа цагаан талхнаас бионүүрсэн талх нь илүү үнэтэй байдаг. Үүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн хэрэглэгчдэд хүргэхийг талх, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд санал болгож байна хэмээн Инноваци, бизнес хөгжлийн төвийн доктор, дэд профессор Б.Мөнхбат хэллээ.

“Цахим математик” төслийн удирдагч Т.Лхагвасүрэн, “Өнөөдөр хүн төрөлхтний хувьд математикийг яаж оновчтой, баяр баясгалан болгох вэ гэдэг асуудал тулгамдаж байна. Үүнийг шийдэхэд бидний хэрэгжүүлж буй “Цахим математик” төсөл онцгой үр дүнтэй. Энэ нь цаг хугацаа, орон зай, багшаас үл хамааран хүүхэд өөрөө бие даан стрессгүй, сонирхолтой хэлбэрээр бодох боломжоор хангасан хөтөлбөр юм. Цэцэрлэгийн насны хүүхдээс эхлээд ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад зориулсан математикийн хөтөлбөрийг энгийн, дунд, ахлах гүнзгийрүүлсэн шатлалтай, англи, монгол хэлний хувилбартай, интернетийн болон интернетийн бус орчинд бодох программ хангамжийг шийдсэнээрээ сонгодог хөтөлбөр. Бүтээгдэхүүнийг нийтэд 2017 оноос нэвтрүүлэхээр ажиллаж байна” гэлээ.

Дашрамд дурьдахад, БСШУСЯ, Монгол Улсын ШУА, Шинжлэх ухаан технологийн сан хамтран зохион байгуулж буй тус үзэсгэлэн хоёр өдөр үргэлжилж, өнөөдөр шилдэг бүтээлүүдийг тодруулах юм байна.

МЭДЭЭЛЭЛ

## Томуугийн дэгдэлттэй холбогдуулан БСШУС-ын сайд чиглэл өгөв

Хүйтний эрч чангарч, улсын хэмжээнд томуугийн вирусын шалтгаантай амьсгалын замын цочмог халдвар нэмэгдэх хандлагатай байна. Эрүүл мэндийн яамны мэдээллээс үзэхэд, томуу болон томуу төст өвчнөөр өвчлөгсдийн 93.1 хувийг 15 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Үүнтэй холбогдуулан БСШУСЯ-аас аймаг болон нийслэлийн БСУГ-т чиглэл өгчээ. Тухайлбал, цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай болон дотуур байранд амьдарч буй суралцагчдад үйлчилж буй хоолны илчлэг, шим тэжээллэг байдал, чанарт байнгын хяналт тавьж, халуун аарц, сүү, байгалийн жимсгэнийн шүүс уулгаж байхыг анхааруулллаа. Мөн суралцагчид болон эцэг эх, асран хамгаалагч нарт ханиад томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө, сургалт зохион байгуулах, Эрүүл мэндийн яамнаас зөвлөмжилсөн “Цэгэн иллэг”-ийг зааврын дагуу заавал хийж сургах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг өгчээ. Харин эцэг, эхчүүдэд хандан өвлийн улиралд хүүхдийг даарч хөрөхөөс сэргийлэн дулаан хувцас, малгай, бээлийг заавал өмсгөж, хэвшүүлэхийг зөвлөсөн юм.

## Оюутнуудад сургалтын төлбөрийн зээлийг олгож эхлэхээр боллоо

Оюутнууд энэ жилээс сургалтын төлбөрийн зээлд хамрагдах боломжтой болсон билээ. Харин зээлийг хэзээнээс олгож эхлэх нь тодорхойгүй байгаа юм. Тэгвэл энэ талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсууриас тодруулахад, “Энэ долоо хоногоос олгож эхлэхэд бэлэн болсон. Цаашид банкуудтай энэ асуудлаар удаан хугацаанд хамтарч ажиллах учраас зээлийн эргэн төлөлт, хууль журам гэх мэтчилэн судлах, хэлэлцэх ажил их байлаа. Арилжааны банк, Монголбанктай гэрээ байгуулах ажил үндсэндээ дууссан. Ингээд зээлийг ойрын хугацаанд олгоно. Энэ долоо хоногоос олгоход бэлэн болсон гэж ойлгож болно” гэж мэдээллээ. Сайд Ж.Батсуурийн мэдээлж буйгаар 2016-2017 оны хичээлийн жилд сургалтын төлбөрөө төлөх боломжгүй 74 мянган оюутан байна. Мөн хоёр болон түүнээс дээш хүүхэд нь зэрэг суралцаж буй өрхийн нэг хүүхдэд олгох сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийг 1500 орчим оюутанд олгох тооцоо гаргажээ. Улсын хэмжээнд 164 мянган оюутан төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургуульд суралцдагийн 125 мянга нь бакалаврын өдрийн ангид сурдаг гэх тооцоог гаргажээ.



NO STRESS

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ




# “Найзууд”

Б.ДАВАА

“Дэлхийн шилдэг гэрэл зураг” буландаа ОХУ-ын гэрэл зурагчин Элена Карневагийн бүтээлийг онцолж байна. Тэрбээр гэр бүл, хүүхдийн зургийн чиглэлээр мэргэшсэн уран бүтээлч бөгөөд Москва хотод байрлан уран бүтээлээ туурвидаг ажээ. Дээрх зураг амьтад болон хүүхдийн нөхөрлөлийг өгүүлэх цуврал бүтээлийнх нь нэг. Гэхдээ дэлхийн авьяаслаг гэрэл зурагчдын чансаагаа сорьдог тэмцээнд ирсэн 4419 зурагнаас оролцсон төрөлдөө дэд байр эзэлсэн бүтээл юм.

Гэм зэмгүй, цав цагаахан өөрийн гэсэн ертөнцдөө амьдрах хүүхдүүд л мал амьтдыг аюул гэж харалгүй жинхэнэ утгаараа нөхөрлөж чаддаг хэмээн зурагчин бүсгүй боддог гэнэ. Ямар нэг буруу ойлголтын уршигаар хүмүүс амьтнаас айдаг бол тэрбээр өөрийн зургуудаараа дамжуулан тэдний айдсыг үгүйсгэхийг зорьсон байна. Тиймдээ ч түүний бүтээлүүдэд хүүхэд, амьтны нөхөрлөлийг бодит өнцгөөс дүрсэлсэн байдаг аж. “Найзууд” гэх энэ бүтээлд бяцхан хүү жижигхэн ишигний хамт модон дээр сууж, дотноор толгойгоо нийлүүлэн буй онцгой агшин ийн буужээ.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -13
Шөнө -22

Нөгөөдөр
Өдөр -13
Шөнө -23

## Өдрийн зурхай

**ӨВЛИЙН ЭХЭН ШАРАГЧИН ГАХАЙ САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР**

**Аргын тооллын:** 2016.11.24, Пүрэв гараг
**Наран ургах шингэх:** 08.12-17.06



*Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйл, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.*

ДУУЛГАХ СОНИН

## Холливудад мөрөө гаргасан А.Баярцэцэг АНУ-ЫГ ЗОРИЛОО

Олон нийтэд олон талаараа үлгэр дуурайлал үзүүлж яваа авьяастай, хөдөлмөрч, зорьсон зорилгынхоо төлөө тууштай тэмцэгч сайхан бүсгүйчүүдийн төлөөлөл бол Дэлхийн гоо сайхны олимпод хүч үзэхээр өнөөдөр АНУ-ыг зорьж буй жүжигчин, мисс, загвар өмсөгч А.Баярцэцэг билээ. “Miss international-2014” тэмцээнд эх орноо төлөөлөн оролцож байсан тэрбээр Байгаль орчноо хайрлан хамгаалахыг сурталчлах зорилготой дэлхийн гоо сайхны тэмцээн болох “Miss Earth” тэмцээнд эх орноо төлөөлөн оролцож, ТОП 16-д шалгарсан юм. Маркетингийн чиглэлээр их сургууль төгссөн мисс бүсгүй маань хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдөн загварын салбарт орж, эдүгээ “Торго” салоны загвар өмсөгчөөр ажилладаг. Мөн тэрбээр хүсэл мөрөөдлөө биелүүлэхээр кино урлагт хөл тавьж, АНУ-ын “Netflix” компанийн бүтээл “Марко Поло” кинонд туслах дүр бүтээсэн нэгэн. Арван жилдээ байхдаа тэрбээр волейболын спортоор дөрвөн жил тасралтгүй хичээллэж байсан бөгөөд одоо долоо хоногтоо хоёр удаа жимээр тогтмол хичээллэж, идэхтэй хөдөлгөөнтэй амьдрахыг эрхэмлэдэг ажээ. “Ану хатан” хэмээх түүхэн томоохон бүтээлээ Америкт гаргасан “Шүүдэр” продакшн “Хотлун гүнж” хэмээх тулаант кино бүтээж эхэлжээ. 2015 оноос бэлтгэл ажил нь эхэлсэн шинэ бүтээлийнх нь гол дүр бөх гүнж хэмээн алдаршсан Хотлун гүнжид жүжигчин, мисс А.Баярцэцэг сонгогдсон байна. Холливудад жүжигчин мэргэжлээр суралцан, “Марко Поло” цуврал болон хэд хэдэн кинонд тоглоод буй А.Баярцэцэг тулааны урлагаар хичээллэдэг, англи, испани хэлтэй нэгэн юм.

Бидэнд тохиолдсон



ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Byambaa Byambaa

Та нар төрөхийн өвдөлтийг тортноос болж зогсоож үзсэн юм уу ккк. Арванхоёрдугаар сарын 31-нд миний төрөх сүүлчийн хугацаа байсан юм. Тэгээд л өвдөхгүй байж байснаа 23:30 цагт гэнэт л өвдөөд эхэлдэг юм даа. Нөхөр сандраад л түргэн дуудчихлаа. Харин би “Гэртээ шинэ оноо гаргаад тортоо идчихээд явна. Төрчихвөл мөддөө амттай юм идэж чадахгүй” гэж тас зөрүүдлээд оноо гаргаад, тортоо идээд байж байтал өвдөлт зогсчихсон байсан. Кккк. Нэг мэдсэн юу ч болоогүй юм шиг салат идээд л сууж байдаг байгаа. Яах аргагүй түргэн дуудчихсан байсан болохоор төрөх эмнэлэг рүү явсан даа. Түргэний эмч ч тайван гэгч нь салат, торт идчихээд явж билээ. Хөөрхий минь манайх руу ирэх замдаа шинэ оноо гаргасан гэсэн.




ОДДЫН АМЬДРАЛ

## Адель хоёр дахь хүүхдээ төрүүлнэ



Хүчтэй хоолой, өвөрмөц дүр төрхөөрөө дэлхий дахинаа алдаршиж чадсан дуучин Адель хоёр дахь хүүхдээ төрүүлэхээр төлөвлөж буйгаа шүтэн бишрэгчиддээ хуваалцжээ. Дуучин бүсгүй эдийн засагч Саймон гэх залуутай хамтран амьдарч буй бөгөөд тэд нэг хүүтэй билээ. Хүү нь эдүгээ дөрвөн настай юм. Тэгвэл “25” нэртэй аялан тоглолтоо хийж буй бүсгүй саяхан Аризона мужид хийсэн тоглолтынхоо үеэр нэгэн төлөвлөгөөгөө танилцуулсан юм. Тэрбээр “Дахиад хүүхэдтэй болох бодолтой байна. Хоёр, гурван жилийн дараа гэхэд би урлагтаа эргэн ирэх болно” хэмээн танхимд цугларсан үзэгчдэд хэлжээ.

## Кэйти Перри Орландо Блумд хаягджээ

Калифорниагийн халуухан муур гэгддэг дуучин Кэйти Перри хаягджээ. Тэрбээр Холливудын царайлаг жүжигчдийн нэг Орландо Блумтай өнгөрөгч нэгдүгээр сараас хойш болзож эхэлсэн байдаг. Хосууд өөрсдийн дотно харилцаагаа шүтэн бишрэгчиддээ ил тодоор зарласан төдийгүй, өнгөрсөн сард болсон сүнсний баярыг ч хамтдаа тэмдэглэсэн юм. Гэвч хосууд салж, уулзалдахаа больсныг тэдний ойрын эх сурвалж мэдээлжээ. Орландо Блум Сүнсний баярын дараа харилцаагаа дуусгахыг хүссэн аж. Тэрбээр Кэйтитэй гэрлэж, хүүхэдтэй болох бодолгүй байгаагаа хэлснээр, мөр мөрөө хөөхөөр болжээ. Орландо Блум өмнө нь 2013 онд гурван жилийн хамтын амьдралдаа цэг тавьж, загвар өмсөгч Миранда Керрээс салсан удаатай. Тэдний хүү эдүгээ таван настай юм.